

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2021-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга хэмжээ/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2020 он/	Санхүүгийн эх үүсвэр /2022-2024/	Зорилтот түвшин /2021-2024	Хэрэгжилт	Хувь
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.							
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: ХҮН АМЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО							
1.1.Хүн амын бүлэг, гэр бүлийн хөгжлийн чиглэлээрх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, шинэчлэх стратегийн зорилтын хүрээнд:							
Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	1.1. Хүн ам, хүн амын бүлэг, гэр бүлийн хөгжлийн чиглэлээрх хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, шинэчлэх	Батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо	Хүн ам, гэр бүлийн чиглэлээр 6 хууль хэрэгжиж байна. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдсэн.	Төсөв: 50.0 сая төгрөг	Хүн ам, гэр бүлийн чиглэлээрх 6 хуулийг шинэчлэн, 2 хуулийг шинээр батлуулсан байна.	Дараах 3 хуулийн төслийг боловсруулж шийдвэрлүүлэхээр ЗГ-т, улмаар УИХ-д өргөн барьсан, Үүнд: 1/ Хүүхэд хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хамт өргөн мэдүүлсэн 14 хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хамт батлагдсан. Хууль 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хуулийг даган гарах дүрэм, журам, стандартыг боловсруулж, ГБХНХ-ын сайдын тушаалаар 1 дүрэм, 5 журам, Засгийн газрын тогтоолоор 1 дүрэм, 2 аргачлал, норматив, Хүүхдийн эрхийн улсын байцагчийн орон тоог батлуулсан. Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын тушаалаар 2 стандарт тус тус батлагдсан. 2/ Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төслийг ХЗДХЯ-тай хамтран боловсруулж, ЗГ-т хүргүүлсэн ба Засгийн газраас хуулийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр УИХ-д өргөн барьсан. 3/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, дагалдан гарах 20-иос дээшгүй хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийн төсөл,	100

					<p>хуулийн тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоо болон хуулийг дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан. Хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 05 дугаар сарын 28-ны өдөр УИХ-д өргөн барьсан.</p> <p>Дараах 4 хуульд нэмэгт өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулан ЗГ-т, улмаар УИХ-д өргөн барьж шийдвэрлүүлсэн, Үүнд:</p> <p>1/ Монгол Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэлэлцэн баталсан. Уг хуулийн нэмэлтээр хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалт бүхий Хүүхдийн төлөө санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд сэргээн байгуулж, сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан.</p> <p>2/ 2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.5-д "хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална" гэсэн нэмэлт орж батлагдсанаар хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг тооцох, санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалттай болсон.</p>
--	--	--	--	--	---

					<p>3/ 2024 онд Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хүүхдийн хөгжлийн үйлчилгээг тодорхойлж, хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг батлан мөрдөх болон хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар хуульчилж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн мэргэжлийн шаардлага, ажилласан жилийн шаардлагыг өөрчилж, Засгийн газраас хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тогтоохоор хуульчилсан. Хуулийн 201 дүгээр зүйл аймаг, дүүргийн Засаг даргын захирамжаар сум, хороонд “Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч” ажиллах хуулийн зохицуулалттай болсон.</p> <p>4/ “Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг нь зохион байгуулагдаж, УИХ-аас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталлуулсан. Хуулийг дагалдан 9 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон ба 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөгдөж эхэлнэ. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн УИХ-ын НББХ-ны дэд ажлын хэсэгт ажиллаж тус хууль, дагалдаж 9 хуулийн төслийн боловсруулсан.</p> <p>Дарааах 3 хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна, Үүнд:</p> <p>1/ Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар хүргүүлээд байна. Хуулийн</p>
--	--	--	--	--	--

						<p>тандан судалгааны тайлан болон хуулийн эхний төслийг боловсруулан ажлын хэсгийн төлөөллөөр 3 удаа хэлэлцүүлсэн.</p> <p>2/ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “32.4. Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасан тул хуулийн төслийг дахин боловсруулж байна. Энэ хүрээнд ТББ-ын төлөөллүүдэд 5 удаа хэлэлцүүлж, хуулийн төсөлд тусгагдаагүй зарим асуудлыг нэмж тусгах хэрэгцээ, шаардлага гарсан тул хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон зардлын тооцоо, хуулийн төсөл, дагалдан гарах хуулийн төслүүдийг шинэчлэн боловсруулаад байна.</p> <p>3/ “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 9 удаа хэлэлцүүлж, ирсэн саналыг тусган ажилласан. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн үзэл баримтлалыг 2024 оны 05 дугаар сард ХЗДХ-ийн сайдтай хамтран батлуулсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “32.4. Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасан тул хуулийн төслийг дахин боловсруулж байна. Хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.</p>	
1.2. Нийгмийн хөгжлийн зорилтот	Салбарын зорилтот хөтөлбөрийн төлөвлөгөөний	-	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Салбарын зорилтот хөтөлбөрийн төлөвлөгөө	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дунд хугацааны буюу 10 жилийн хугацаатай дараах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:	-	

	хөтөлбөр хэрэгжүүлэх	хэрэгжилтийн хувь			батлагдаж, хэрэгжилт 30-аас доошгүй хувь байна.	<p>-Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр; -Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; -Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; -Байгаль орчны зорилтот хөтөлбөр; -Засаглалын зорилтот хөтөлбөр; -Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; -Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр.</p> <p>Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг нийгмийн хөгжлийн талаарх олон улсын хэмжээнд баримталдаг ойлголт, онол, үзэл баримтлалыг судалж хэлэлцэн</p> <ol style="list-style-type: none"> 1.Хүн амын өсөлт, бүтэц 2.Өрх, гэр бүл 3.Хүнд ээлтэй орчин 4.Хөдөлмөр эрхлэлт 5.Нийгмийн хамгаалал гэсэн агуулгын хүрээнд боловсруулсан. <p>Зорилтот хөтөлбөр батлагдсаны дараа салбар бүрт зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.</p> <p>Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 57 дугаар захирамжаар, дэд ажлын хэсгийн Эдийн засгийн хөгжлийн сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Хөтөлбөрийн төслийг боловсруулан 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 07 дугаар сарын 08-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Гэвч Эдийн засгийн хөгжлийн яамнаас уг төслийг буцаан татаж авсан.</p>	
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
<i>Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.</i>							

<p>Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.</p>	<p>1.3.Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагын чадавх, манлайллыг бэхжүүлэх</p>	<p>Албан хаагчийн тоо, батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо</p>	<p>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн салбарт нийт 1054 албан хаагч ажиллаж байна.</p>	<p>Төсөв: 200.0 сая төгрөг</p>	<p>Нийгмийн ажлын нийтлэг үйлчилгээний стандартын хэрэгжилтийг бүрэн хангана. Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны үйл ажиллагаа тогтмолсон байна. Нийгмийн ажилтны мэдээллийн санг ажиллуулна.</p>	<p>1.Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийг /Шинэчилсэн найруулга/ дагалдуулан Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын салбарын нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх хүрээнд дараах дүрэм, журам, аргачлал, зааврыг боловсруулж, батлуулсан. Үүнд: а. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм, б. Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх аргачлал, заавар, в. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам. г. Сум хороонд ажилллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэт, аргачлал 2. 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар “Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал болон сум, хороонд ажиллах нийгмийн ажилтны орон тоо”-г улсын хэмжээнд нийт 833 байхаар тогтоосон. 3. Гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг эрхлэх төр, ТББ, мэргэжлийн холбоо, нийгмийн хамгаалал, халамж, олон нийгмийн байгууллагын мэргэжилтэн, албан хаагчдад мөрдүүлэх “Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 7038:2024 стандарт 2024 онд батлагдсан бөгөөд стандартын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Гамшгийн үед гэр бүлийн гишүүдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх,</p>	<p>100</p>
--	--	---	---	--------------------------------	--	---	------------

					<p>хүчирхийллээс хамгаалахад Хамтарсан багийн гишүүд, нийгмийн ажилтан, сум, багийн Засаг дарга нарт мэдлэг, ойлголтыг өгч, хамгааллын үйлчилгээ үзүүлэх ур чадварыг нэмэгдүүлэх агуулга бүхий сургалтын модуль боловсруулж, Дэлхийн зөн ОУБ, Мэргэжлийн холбоодын төлөөллийн хамтаар орон нутгийн албан хаагчдад сургалт хийсэн. Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага стандартыг /MNS 7038:2024/ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны С/12 дугаар тушаалаар батлуулсан. Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтсээс гадна нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд баримтлана. Яамнаас ХГБХХЕГ-т, ХГБХХЕГ-аас аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс, гэр бүлийн зөвлөгөө өгөх төвд уг стандартын дагуу үйл ажиллагаа явуулах чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>4. Нийгмийн ажилтны ёс зүйн хороо</p> <p>а. Нийт нийгмийн ажилтны мэргэжлийн ур чадвар, ёс зүй, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, сургаж, чадавхжуулах, кэйс менежрийн ур чадварыг сайжруулах зорилгоор Аймаг, нийслэл, дүүрэг бүрт нийгмийн ажлын ёс зүйн хороод 2024 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл ажилласан. Энэ өдрөөс Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ хуулийн шинэчлэлтэй холбогдуулан Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг ГБХНХСайдын 2024 оны 10-р сарын А/32 дугаар тушаалаар шинээр баталсан. 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш сум, дүүрэгт бүрэн томилогдон ажиллаж</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>эхэлсний дараа Ёс зүйн хороог дахин шинэчлэн байгуулна.</p> <p>б. “Нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүйн хорооны гишүүдэд зориулсан гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах” ажлыг 2023 оны 12-р сард “Нийгмийн ажлын багш сургагчдын холбоо” ТББ-гаар гэрээлэн гүйцэтгүүлсэн. “Нийгмийн ажлын ёс зүйн хорооны гишүүн, шинжээчийн гарын авлага” нь нийгмийн ажлын үйлчилгээ, нийгмийн ажилтанд тулгарч болзошгүй ёс зүйн зөрчил, түүнтэй холбоотой асуудалд дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх арга замыг тодорхойлж, дүгнэлт гаргах ур чадварыг эзэмшүүлэх модуль бүхий анхны гарын авлага юм. Гарын авлагыг 300 ширхэг хэвлүүлж, тархаасан.</p> <p>в. Нийгмийн ажлын ёс зүйн хорооны гишүүн, шинжээчийн гарын авлагын сургалтыг 2023 оны 12 дугаар сарын 28, 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд 2 шатлалтайгаар зохион байгуулсан. Сургалтад Нийгмийн ажлын ёс зүйн хорооны гишүүд оролцсон.</p>	
1.4. Гэр бүлд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох.	Стандартын шинэчилсэн төсөл-1 Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн хүний тоо	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн гэр бүлийн боловсрол олгох 164 удаагийн танхимын болон цахим сургалтад 29960 хүн /хандалт 168503/, угийн бичгийн	Төсөв: 50.0 сая төгрөг	Гэр бүлд зөвлөгөө өгөх тавих нийтлэг шаардлага MNS 6417:2013 стандартыг шинэчлэн боловсруулж батлуулна.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны А/40 тушаалаар байгуулагдсан Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд тавих нийтлэг шаардлага MNS 6417:2013 стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд тавих нийтлэг шаардлага MNS 6417:2013 стандарт нь шаардлагад нийцэж байгаа тул гэр бүлд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, сайжруулах зорилгоор “Гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага” стандартыг шинээр боловсруулан Стандарт, хэмжил зүйн газарт 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 03/3006 тоот албан бичгээр хүргүүлсний дагуу Стандартын техникийн хорооны гишүүдийн 2023 оны 12 дугаар сарын хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Стандарт,	100	

						<p>хэмжил зүйн газрын даргын 2024 оны С/12 дугаар тушаалаар /MNS 7038:2024/ батлуулсан.</p> <p>Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв болон танхимууд дээр дурдсан 2 стандартыг мөрдөн ажиллаж, 2021-2024 онд давхардсан тоогоор зөвлөн туслах хөгжлийн үйлчилгээг нийт 136474 иргэнд үзүүлснээс сэтгэл зүйн, хууль эрх зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг 15687 иргэнд өгсөн. Гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга эзэмшүүлэх, угийн бичиг хөтлөх, зан үйлд нөлөөлөх зэрэг чиглэлээр сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 775356 иргэнийг хамруулсан байна.</p>	
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
Зорилт 1. Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.							
<p>Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.</p>	<p>1.5.Эрүүл насжилтыг дэмжих, ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний цогц загварыг туршиж нэвтрүүлэх</p>	<p>Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загвар, Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны эзлэх хувь</p>	<p>АХБ-тай хамтран эрүүл насжилтыг дэмжих, урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх туршилтын төслийг хэрэгжүүлж эхэлж байна.</p>		<p>Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг нэвтрүүлсэн байна. Нийт ахмад настны 20-оос багагүй хувьд үйлчилгээ үзүүлсэн байна.</p>	<p>Азийн хөгжлийн банктэй хамтран “Олон нийтэд түшиглэсэн урт хугацааны тусламж, үйлчилгээг хөгжүүлэх нь” техник тусалцааны ТА 9928 төслийг 2021-2024 онд хэрэгжүүлсэн.</p> <p>Төсөлд Дархан-Уул аймгийн “Ахмадын хөгжлийн төв”, сумын түвшинд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлэг, дүүргийн түвшинд Сонгинохайрхан дүүргийн “Ачлалт хүүхдүүд” төрийн бус байгууллагыг хамруулсан.</p> <p>Урт хугацааны тусламж үйлчилгээний загвар турших төслийг үр дүнд хүргэх зорилгоор 2022 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/127, А/333 дугаар тушаалаар “Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар турших төлөвлөгөө”-г баталсан.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд: -Ачлалт хүүхдүүд төрийн бус байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон харж хандах хүнгүй ахмад настнуудад төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлж, 2023 оноос</p>	70

					<p>эхлэн Сонгинохайрхан дүүргийн 28, 11 дүгээр хорооны Ахмадын хороо, өрхийн эмнэлэгтэй хамтран кейс менежментийн үйлчилгээг туршин нэвтрүүлсэн.</p> <p>-Дархан-Уул аймгийн Ахмадын хөгжлийн төв нь төвд суурилсан, өдрийн үйлчилгээ, ахмадын хөгжил, оролцоо, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ, идэвхтэй насжилтын цогц үйлчилгээ, 2, 3 дугаар түвшний ахмадуудад явуулын үйлчилгээг нэвтрүүлсэн.</p> <p>-Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлэг нь Амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх, түргэн тусламж, оношилгоо, сэргээн засах үйлчилгээг үзүүлж, нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн идэвхтэй насжилт, явуулын үйлчилгээг нэвтрүүлсэн.</p> <p>Дээрх 3 төв нь ахмад настанд цогц үйлчилгээг үзүүлэх, төр болон төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтэн зэрэг орон нутгийн нөөц боломжийг уялдуулах түвшинд үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Сонгосон 3 төвд Идэвхтэй насжилтыг дэмжих төвөөр 2022-2024 онд давхардсан тоогоор 37,469 ахмад настанд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Ачлалт хүүхдүүд төрийн бус байгууллагын дэргэд байгуулсан төвөөр тухай Сонгинохайрхан дүүргийн нийт ахмадын 53 хувь, - Дархан-Уул аймгийн ахмадын хөгжлийн төвөөр аймгийн нийт ахмадын 90 хувь, - Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийг түшиглэн байгуулсан төвөөр сумын нийт ахмадын 80.1 хувь <p>Мөн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ахмад настны цогц үнэлгээ хийж, ахмад настны цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээний мэргэжлийн</p>
--	--	--	--	--	---

						<p>удирдлагаар хангах зэрэг зохицуулалт шинээр тусгагдсан.</p> <p>Хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын, 2024 оны А/76, А/515 дугаар хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, А/75, А/514 дүгээр тушаалаар “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмаар Ахмад настны цогц үнэлгээгээр үйлчилгээг үзүүлэх болон 1 дүгээр түвшний ахмад настанд Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг лавлагаа, мэдээллийн, ахмад настны хөгжлийг дэмжих, ахмад настны зөв хооллолт, дасгал, хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих, зөвлөгөө өгөх, сайн дурын гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээнүүдийг хамруулан цогц хэлбэрээр үзүүлэхээр тусгасан.</p>	
1.6.Хүүхэд хамгаалалд зориулсан зардлыг одоогийн хүрсэн түвшнээс бууруулахгүйгэр цаашид нэмэгдүүлэн, үр дүнд суурилсан санхүүжилтийг олгох, зарцуулалтын үр ашгийг сайжруулах	Хүүхэд хамгааллын зардлын хэмжээ, тэрбум төгрөгөөр	Улсын төсвөөс хүүхэд хамгааллын арга хэмжээнд 2019 онд 7,6 тэрбум, 2020 онд 8 тэрбум төгрөг зарцуулсан.	Төсөв: 5.2 тэрбум төгрөг	8,0 тэрбум төгрөгөөс бууруулахгүй.	<p>1/ Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2017 оноос хойш хүүхдийн хамгаалал, хөгжлийн чиглэлээр зарцуулсан хөрөнгө 2017 онд 900.1 сая төгрөг байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 6.4 тэрбум төгрөг, 2021 онд 8.0 тэрбум төгрөг, 2022 онд 8.0 тэрбум, 2023 онд 7.9 тэрбум, 2024 онд 13.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс баталсан.</p> <p>2/ Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд хамгааллын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгож, дараах зохицуулалтыг шинээр тусган баталсан.</p> <p>- Хуулийн 52.2-т “Хүүхэд хамгааллын санхүүжилтийг энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, хэлбэр тус</p>	100	

					<p>бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.”</p> <p>- Хуулийн 52.3-т “Хүүхэд хамгааллын санхүүжилтийг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн дараа онд олгох санхүүжилтийг тогтооно.”</p> <p>- Хуулийн 52.4-т “Төр хүүхэд хамгааллын асуудлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлж, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.”;</p> <p>- Хуулийн 52.6-д “Засгийн газрын гишүүд эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, энэ хуулийн 30.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээ авна.”;</p> <p>- Хуулийн 52.7-д “Хуулийн этгээд өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна.” гэж хуульчилсан. ГБХНХЯ-аас хуулийн 52.8-д заасны дагуу “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив”-ыг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p>	
1.7.Хүүхэд хамгааллын үйлчилгээний	Хүүхэд хамгааллын үйлчилгээ	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа	Төсөв: 500.0 сая төгрөг	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон эдгээр хуулийг даган	100

<p>чанар хүртээмжийг нэмэгдүүлж эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх</p>	<p>авсан хүүхэд, гэр бүлийн тоо, үр дүн</p>	<p>31 асрамж, халамжийн төвд 1069 гаруй хүүхэд амьдарч байна. Хүүхэд харах үйлчилгээ 2021 оноос ХНХЯ, салбар хэрэгжүүлнэ.</p>		<p>шаардлагатай хамгааллын үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна.</p>	<p>гарсан гаруй дүрэмж, журам, стандартыг хүүхэд хамгааллын үйлчилгээнд мөрдөн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамгаалах шаардлагатай хүүхдүүдийг бүрэн хамруулан ажиллаж байна: 2021 оны жилийн эцсийн байдлаар эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй 715 Хамтарсан баг ажиллаж, 6207 кейс бүртгэгдэж, 3084 кейс шийдвэрлэж, 3281 кейстэй ажиллаж, 9321 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулсан байна. ХХ үйлчилгээ авсан нийт хүүхэд 2022 онд нийт 25487, 2023 онд 31501, 2024 онд 28658 хүүхэд байна. Үүнээс: Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд-2022 онд 14207, 2023 онд 15905, 2024 онд 13291, Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд -2022 онд 369, 2023 онд 469, 2024 онд 331, Хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн хүүхэд-2022 онд 1491, 2023 онд 1840, 2024 онд 1162, Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд -2022 онд 303, 2023 онд 618, 2024 онд 410, Уралдаанч хүүхэд -2022 онд 7596, 2023 онд 11207, 2024 онд 11723 хүүхэд, Хараа хяналтгүй хүүхэд -2022 онд 120, 2023 онд 117, 2024 онд 293 хүүхэд, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхэд 2022 онд 3226, 2023 онд 3381, 2024 онд 2546 хүүхэд байна. Урьдчилан сэргийлэх 2021 онд “Хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын тушаалаар зохион байгуулж, 78 арга хэмжээ зохион байгуулж, 50560 хүнд хүрч ажилласан байна.</p>	
--	---	---	--	--	--	--

					<p>2022 онд Урьдчилан сэргийлэх талаар 7474 төрлийн зөвлөмж, мэдээлэл, зурагт хуудас, мэдээ, давхардсан тоогоор 2999 удаагийн видео, TV нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээсэн.</p> <p>“Эрүүл аюулгүй орчин”, ”Бид хамтдаа” “Хүүхдээ хамгаалъя” “Тоглоомын талбай” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй 256, эрсдэлт нөхцөл бүхий 560, хараа хяналт сул 410 хүүхдийг олж илрүүлэн холбон зуучлаж, эцэг, эхийн хараа хяналт сул 26 хүүхдийг хамгаалах байр, нэг цэгийн үйчилгээнд хүргэж хороодын хамтарсан багт холбогдох мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг 2022 онд 381000 хүүхэд, 2023 онд 431000 хүүхэд, 2024 онд 386000 хүүхэд авсан байна.</p> <p>2023 онд Эрсдэлийн программд бүртгэлтэй 8656 хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээ, 5878 хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж ажилласан. Эрсдэлийн программд бүртгэлтэй 15,905 хүүхдийн 14534 хүүхдэд буюу 91,3 хувьд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>2024 онд эрсдэлт нөхцөлд амьдарч буй 4,478 хүүхдийг шинээр илрүүлэн эрсдэлийн программд бүртгэж, насанд хүрсэн, эрсдэлгүй болсон 3,515 хүүхдийг бүртгэлээс хассан. Жилийн эцсийн байдлаар эрсдэлийн программд нийт 15,905 хүүхэд бүртгэлтэй байгаагаас эрсдэлийн түвшин өндөр 3474, дунд 3730, бага 5065, эрсдэлд өртөх магадлалтай 3636 хүүхэд байна. Аймаг, нийслэлд хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3239 арга хэмжээ, нөлөөллийн ажил зохион байгуулж, 134,968 хүүхдийг хамруулсан.</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>Эрсдэлийн программд бүртгэлтэй 15,905 хүүхдийн 14534 хүүхдэд буюу 91,3 хувьд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Цахим орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 22 постер, 22 рийл бэлтгэн олон нийтэд хүргэж, 781,881 хандалт, 306,168 түгээлт, 7603 хүнд таалагдсан байна.</p> <p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 60195 хүнд хүргэж, мэдлэг, мэдээлэл олгосон</p> <p>2024 онд Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт зохион байгуулж, 318,380 насанд хүрэгч, 3,688 хүүхдийг хамруулсан.</p> <p>-Хүүхдийн эрхийн зөрчил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох мэдлэгийг 318,380 насанд хүрэгч буюу 14,6 хувьд хүргэсэн. - Хүүхдийн эрхийн зөрчил, мэдээлэлд кейс үйлчилгээ үзүүлэх арга зүйн сургалтад 15,931 албан хаагчдыг хамруулсан.</p> <p>Хүүхдэд эрсдэл учруулах 3,819 орчныг илрүүлж, эрсдэлийг арилгуулсан.</p>	
1.8.Хүүхдийн ордон, театр хөгжлийн төвүүдийг нэмэгдүүлж, хөгжлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Шинээр байгуулсан зуслангийн тоо	Улсын хэмжээнд хүүхдийн хөгжлийн ордон 15, хөгжлийн төв 6, хүүхдийн 4 театр байна. /13 аймаг, 3 дүүрэгт /2-25 төрлийн дугуйлан хичээллэж байна. Бүртгэлтэй 42	Улсын Төсөв: 30.0 тэрбум төгрөг	“Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зуслан, орон нутагт хүүхдийн хөгжлийн төв, зуслан байгуулж, хүүхэд хөгжлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	<p>1. Монгол Улсын Засгийн газрын “Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслан байгуулах тухай” 2020 оны 205 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 33 дугаар хуралдааны 33 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд.</p> <p>- Олон улсын хүүхдийн “Найрамдал-2” зуслан байгуулах зориулалтаар Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны нутаг /Хөвсгөл нуурын эрэг/-т нийт 60 га талбайн газар эзэмших эрхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд олгосон</p> <p>- Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслангийн дунд болон урт хугацааны</p>	90	

			<p>зуслан байгаас үйл ажиллагаа явуулж буй 35 зуслан байна. Улсын 14, хувийн 23, ОНӨҮГ 5 байна. Нийслэлийн 15, орон нутгийн 20 зуслантай.</p>		<p>хөгжлийн бодлого, стратегийг боловсруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/129 дүгээр тушаалаар Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслан байгуулах бодлого зохицуулалт, бэлтгэл ажлыг хангаж ажиллах чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулсан. - Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслангийн зураг төслийн 3D видео танилцуулгыг хийсэн. - Уг цогцолборын төсөв цэвэрлэх байгууламжийн зураг төсөв тооцогдоогүйгээр 136 тэрбум 721 сая 342,6 мянган төгрөгөөр боловсруулагдсан. Батлагдсан төсөв болох 30 тэрбум төгрөгт багтах барилга байгууламжийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер дахин зарлагдсан боловч оролцогч байхгүй тул амжилтгүй болсон. /3 удаа/. Санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул барилгын ажил эхлээгүй. <p>2. УИХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр дараах зохицуулалт туссан. Хуулийн 6.5-д “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага үйлчилгээний бодлого, хөтөлбөртэй байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллана.”, 6.6-д “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж хуульчилсан. Энэ хүрээнд Сангийн яамтай хамтран Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын төслийг</p>
--	--	--	---	--	---

					<p>боловсруулж, олон нийтээс санал авч хэлэлцүүлж байна.</p> <p>3. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлуулсан. Журмын шинэчлэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих; - Хүүхдэд зориулсан барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх; - Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зохицуулалт тусган, хүрээг тогтоосон. <p>4. 2024 онд хүүхдийн зуслангийн өвлийн болон зуны ээлжид 91,801 хүүхэд хамрагдсан. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 504 хүүхэд үнэ төлбөргүй хамрагдсан байна. Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрт нийт 1 тэрбум 182 сая төгрөг зарцуулсан байна.</p> <p>5. Улсын хэмжээнд бүртгэлтэй 55 зуслан байгаагаас 43 зуслан тогтмол үйл ажиллагаа явуулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/150 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн жишиг хөтөлбөр”-т нийцүүлэн хөтөлбөр хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт 2023 онд 73,964 хүүхдийг буюу хөтөлбөрт хамрагдах насны (6-17 насны 825,638 хүүхэд) хүүхдийн 9,0 хувийг хамруулсан. Улсын хэмжээнд 15 хүүхдийн хөгжлийн ордон, 6 хөгжлийн төв, 4 хүүхдийн театр, үйл ажиллагаа явуулж, 4-25 төрлийн дугуйлан, сургалт хөтөлбөрт жилдээ 132.0 мянган хүүхэд буюу нийт хүүхдийн 10,5 хувийг хамруулж байна.</p> <p>6. Хүүхдийн хөгжлийг дэмжих зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх ажлын хүрээнд 2024 онд Архангай, Өвөрхангай аймагт 70 сая, Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймагт 101 сая 500 мянга, Дархан-Уул,</p>
--	--	--	--	--	---

						Сэлэнгэ аймагт 87 сая 500 мянга, Орхон аймагт 45 сая 500 мянга, Дундговь, Говьсүмбэр, Төв аймагт 84 сая, Хөвсгөл, Булган аймагт 73 сая 500 мянга, Завхан, Увс, Баян-өлгий аймагт 103 сая 250 мянга, Өмнөговь, Дорноговь 54 сая 250 мянга, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймагт 82 сая 250 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	
	1.9.Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийт, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Улсын хэмжээнд нийт 3821 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулагдсан .	Төсөв: 200.0 сая төгрөг	Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, байгууллагын дэргэдэх зөвлөлийн тоог 2 дахин нэмэгдүүлнэ. Эцэг, эх олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.	1. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн 10,053 дарга, нарийн бичгийг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр арга зүйгээр хангаж, 217,681 албан хаагчдад гэр бүлийн боловсрол, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сэдвээр мэдлэг олгож, 62,841 албан хаагчдыг хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй, хөгжлийн үйл ажиллагаанд хамруулсан. -2024 онд шинээр 1084 байгууллага хүүхэд хамгааллын бодлого баталж, 276 байгууллага хүүхдийн ерөө тохижуулан, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн. Улсын хэмжээнд 2020 онд 3362, 2021 онд 3821 эцэг, эхийн зөвлөл байсан бол 2024 онд 7050 эцэг, эхийн зөвлөл ажиллаж байгаа бөгөөд 2020 оныхоос 2,1 дахин, 2021 оныхоос 1,9 дахин нэмэгдсэн. 2/ Хүүхэд хамгааллын тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/ 30.4-т “Ажил олгогч, хуулийн этгээд дотооддоо хэрэгжүүлэх байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.” гэж, 30.5-д “Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн	100

					<p>хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэж хуульчилсан.</p> <p>Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4 дэх заалттай уялдуулан Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4.3-д “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл нь хүүхэд хамгааллын жишиг бодлогыг батлах.” гэж хуульчилсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”, тогтоолын 1,2 дугаар хавсралтыг шинэчлэн боловсруулж байна.</p>	
1.10.Аймаг, дүүргүүд дэх Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүд болон салбарууд дахь Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шийдвэрийн хэрэгжилтийн хувь	Шийдвэрийн хэрэгжилтийн хувь	Улсын хэмжээнд 436 Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулагдаж 7000 орчим залуучууд хүсэл сонирхлоороо нэгдээд байна.		Залуучуудын хөгжлийн зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг 100 хувь хангана.	<p>2023 оны байдлаар “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийг баталж, улсын хэмжээнд Залуучуудын хөгжлийн нийт 436 зөвлөл байгуулагдаж, 7 мянга гаруй залуучууд гишүүнээр бүртгэгдээд байна. Үүнд 21 аймаг, 9 дүүрэг, 56 сум, 124 хороо, 13 яам, агентлагийн дэргэд 78 зөвлөл, төрийн болон ААНБ-ын дэргэд 133 зөвлөл, сонирхлын 3 зөвлөл байна. Мөн шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог хангах зорилго бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахалж, аймаг, дүүргүүдэд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүд ажиллаж, орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцсэн Залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд: нийт 339 сум, 9 дүүрэгт Залуучуудын салбар зөвлөлүүд байгуулагдан ажиллаж байна.</p> <p>ССАЖЗЯ РУУ ЧИГ ҮҮРЭГ ШИЛЖСЭН</p>	

	1.11.Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйлчилгээний чанар, хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлэх	Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын хувь	Залуучуудын хөгжлийн төв бүх аймаг, дүүрэг, зарим сумдад ажиллаж амьдрах ухаан, эрүүл мэнд, нөхөн үржихүйн сургалт, арга хэмжээнд 2024 онд залуучуудын 41 хувийг хамруулсан.		Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээнд хамрагдагчдын тоог нийт залуучуудын 45 хувьд хүргэнэ.	Залуучуудын үйлчилгээний төвийн үйлчилгээний стандартын төсөл болон хүүхэд, өсвөр үеийн хөгжил, хамгааллын бусад холбогдох стандартын төслийг боловсруулж холбогдох хороогоор хэлэлцүүлснээр "Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төв, үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 7012:2023 стандарт"-ыг батлуулсан. Аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн 43 төвөөр 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 414007 залуучууд буюу 15-34 насны нийт залуучуудын 41 хувь нь хамрагдаж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих 7 төрлийн үйлчилгээ авсан байна. ССАЖЗЯ РУУ ЧИГ ҮҮРЭГ ШИЛЖСЭН	-
	1.12.Залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын санал, санаачлагыг дэмжих, төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Монголын залуучуудын эвсэл, залуучуудын холбоо зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай үндэсний чуулган зохион байгуулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна.		Залуучуудын иргэний нийгмийн, төрийн бус байгууллагуудын санал, санаачилгыг дэмжиж, 10-аас доошгүй арга арга хэмжээг хамтран хэрэгжүүлсэн байна.	Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд хөгжлийн үндэсний чуулганыг угтаж, 3 шатны хэлэлцүүлгийг 2023 оны 08 дугаар сард дараах байдлаар зохион байгуулав. Үүнд: 1. Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл; 2. Хувийн хэвшил дэх залуучуудын төлөөлөл; 3. Яамд, салбар зөвлөлийн гишүүд, төрийн байгууллагын залуучуудын төлөөлөл. Эдгээр хэлэлцүүлэгт нийт 84 залуучууд танхимаар, 102 залуучууд цахимаар оролцож Залуучуудын үндэсний болон салбар зөвлөлийн дүрмийн өөрчлөлт; Сайн дурын ажилтан бүртгэх, баталгаажуулах журмын өөрчлөлт; Магадлан итгэмжлэх журмын төсөл; Тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд залуучуудын иргэний нийгмийн байгууллагын хувь нэмрийн талаар хэлэлцэж, санал, шүүмж, дүгнэлтийг нэгдсэн чуулганы зөвлөмжид тусгасан. Мөн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой	-

					<p>холбогдуулан мэдээлэл өгөх, санал солилцох, зөвлөлдөх уулзалтыг залуучуудын иргэний нийгмийн байгууллагууд, аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн удирдлагууд, Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүдтэй 2023 оны 06-07 дугаар сард зохион байгуулж оролцоог дэмжсэн.</p> <p>“Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуучуудын бүтээлч хамтын оролцоо” залуучуудын хөгжлийн үндэсний 9 дүгээр чуулганыг Монголын залуучуудын өдөр буюу 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, төрийн, иргэний нийгмийн, олон улсын байгууллагын зочид, төлөөлөгчид, залуучууд олон нийтийн төлөөлөл танхимаар 680, цахимаар 4500 гаруй залуучууд оролцож, залуучуудын өмнө тулгамдсан эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих эрх, нийгмийн оролцооны асуудлыг хэлэлцэж, чуулган угтсан дэд хэлэлцүүлгүүд, чуулганы үндсэн болон салбар хэлэлцүүлгээр дэвшүүлсэн санал, шүүмжийг нэгтгэн 7 чиглэл бүхий зөвлөмжийг залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс төрийн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>ССАЖЗЯ РУУ ЧИГ ҮҮРЭГ ШИЛЖСЭН</p>	
1.13.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлийн хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр 188.0 мянган төгрөг		Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 15-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	<p>Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаар 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн батлуулсан. Мөн Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоов. Үүнд:</p>	100

						<ul style="list-style-type: none"> •Нийгмийн халамжийн тэтгэвэр 288 мянгаас 325 мянган төгрөг, •Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 288 мянгаас 325 мянган төгрөг, •Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж 84.5 мянгаас 275 мянган төгрөг, •Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэний тэтгэмж 123.1 мянгаас 275 мянган төгрөг <p>Нэмэгдэлийн хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 12.3%, 2020 оноос хойш нэмэгдээгүй байсан асаргааны тэтгэмжийн хэмжээ 2.2-3.2 дахин нэмэгдэв. 2023 онд Хүн амын амьжиргааны түвшин бүсүүдийн дундаж 282,880 төгрөг байгаа ба тэтгэврийн хэмжээ 07 сараас нэмэгдсэнээр АДТ-ээс 12.9 хувиар илүү болсон. Мөн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 375,000 төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг 302,500 төгрөг болгон нэмэгдүүлсэн. 2024 оны 10 дугаар сарын мэдээгээр нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид нийт 381.4 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан санал авч байна. Монгол Улсын 2025 оны төсөвт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 27.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг баталсан.</p>
		Хөдөлмөр эрхлэлтийн	Хөгжлийн бэрхшээлтэй	Улсын төсөв	Хөтөлбөрийн хүрээнд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт

		үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2020 оны байдлаар 2844 хүн хамрагдаж, 1089 хүн байнгын ажлын байртай болсон байна		Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоог 50-аас багагүй хувиар нэмэгдүүлнэ.	2021-2024 онд нийт 39.5 тэрбум төгрөг төсөвлөж 30.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 14839 иргэнийг хамруулан 4043 байнгын ажлын байрыг бий болгосон. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 онд 3.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн бол 2022 онд 11.7 тэрбум төгрөгийг, 2023 онд 11.4 тэрбум төгрөгийг, 2024 онд 12.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулахаар төсөвлөж, санхүүжилтийг нэмэгдүүлсэн. Түүнчлэн зорилтот бүлгийн иргэдэд зориулсан (хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан, оюутан залуучууд гэх мэт) хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлэх “Job center” төвийг 2024 онд Улаанбаатар хотын 4 байршилд байгууллаа. “Job center” төвд дараах үйлчилгээ үзүүлнэ: - Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх; - Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах; - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх; - Ажилд зуучлах; - Ажил олгогчид зориулсан зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах; - Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах; Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй бодлого, хууль тогтоомжийн талаарх мэдээллээр хангах.	
1.14. Дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулж,	Хүртээмжтэй барилга, байгууламж, замын байгууламж,	-		Улсын төсөв	Хүртээмжтэй дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийн үнэлгээ, судалгаа	Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 2021-2024 онд “Түгээмэл хөгжил төв” ТББ, “Эрчис тэргэнцэр засвар зөвлөгөө мэдээллийн төв” ТББ-тай хамтран	100

	<p>хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүх харилцаанд бүрэн дүүрэн эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх</p>	<p>цахим сайтын үнэлгээ судалгаа, Сургалт, нөлөөллийн арга хэмжээ</p>			<p>хийгдэж, үндэсний хэмжээнд сургалт, нөлөөллийн арга хэмжээ тогтмолжсон байна.</p>	<p>нийслэлийн 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Архангай, Хэнтий аймгуудын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын 11 газар, ЧД-ийн ерөнхий боловсролын 17, 23, 37, 49, 65, 72, 76, 107, 138, 149, 153 дугаар сургуулиудын нийт 22 барилга байгууламжид хүртээмжийн үнэлгээг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох, спортоор хичээллэхэд барилга байгууламжийн дэд бүтцийг MNS 6055:2009, MNS 6808:2019 стандартын шаардлагын дагуу төлөвлөх, гадна хаяг, орц гарц, налуу зам, үүдний босго, бариул, гэрэлтүүлэг зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх, байгууллагуудын багш ажилтан албан хаагчид дохионы хэлний мэдлэгтэй байх, туслах ажилтан ажиллуулах зэрэг шаардлагатайг тусгасан.</p> <p>Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 14 газрын дараах байршлуудад явган хүний зам талбайн дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээг MNS 6055:2009, MNS 6808:2019 стандартын дагуу хийж ажилласан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төв шуудан - Цэцэг төв - Монгол банк - Монголын ипотекийн корпорац - Үндэсний түүхийн музей - Цаг уур орчны шинжилгээний газар - Нийслэлийн Засаг Захиргааны 4 дүгээр байр - Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг - Үндэсний түүхийн музей - Чингис хаан музей - Нэгдүгээр дэлгүүрийн уулзвар - СУИС-ийн уулзвар - Монголын хүүхдийн ордон 	
--	---	---	--	--	--	---	--

					<p>- Спортын төв ордон зэрэг газрууд хамрагдсан ба үнэлгээний тайланг үндэслэн зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлсэн. Мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр 2021-2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2022 онд доор дурдсан 16 цахим хуудсанд үнэлгээ хийсэн нь бүгд хүртээмжтэй байдлын шаардлагад нийцээгүй, шалгуур хангасан үзүүлэлт байхгүй байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ХБХХЕГ gadpwd.gov.mn 2. Худалдаа хөгжлийн банк tdbm.mn 3. Номин супермаркет eshop.nomin.mn 4. Е-баримт ebarimt.mn 5. Look TV looktv.mn 6. lkon news ikon.mn 7. Unread news unread.mn 8. Халамжийн нэгдсэн систем ehalamj.mn 9. Өргөө кинотеатр urguu.mn 10. Zindaa.mn 11. Livetv.mn 12. Zarig.mn 13. News.mn 14. Montsame.mn 15. Gogo.mn 16. Dnn.mn <p>Мөн И-Монголиа академи УТҮГ-тай хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүн И-Монголиа системд нэвтэрч төрийн үйлчилгээг хүртээмжтэй авах боломж бүрдүүлэн ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй, сул хараатай, гэрэлд мэдрэг, сурахад хэт мэдрэг зэрэг хүнд зориулсан тусгай хүртээмжийн тохиргоог гар утсанд суулгах И-Монголиа аппликейшнд нэвтрүүлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх авах цэс нэмж оруулсан. 2022 онд ХБХХЕГ-аас ЦХХЯ, И-Монголиа академийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлагын хичээл</p>
--	--	--	--	--	---

					<p>ордог байсан бол 2023 онд И-Монголиа академи нь 308 хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцаж тэдэнд аппликейшн хэрхэн хэрэглэх сургалт оруулсан бөгөөд Хурдан үйлчилгээ нэвтрүүлж ТҮЦ үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрэгтэй үйлчилгээг хүргэн ажиллаж байна.</p> <p>МУИС-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Ярьдаг, сонсдог номын сан ашиглалтанд оруулсан, бичдэг үзэг, томруулагч, компьютерт сурилуулсан апп болон брайль төхөөрөмж, дэлгэц зэргийн тусламжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд хүртээмжтэй орчинд хичээл давтах өрөө, номын сантай болсон.</p> <p>Мөн байгууллага тус бүрээс 3 нийт 33 хүнд үнэлгээ хийх арга, аргачлал, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчныг бүрдүүлэх талаарх сургалтыг танхим болон цахимаар 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Үнэлгээнээс гарсан тайланг боловсруулж, зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.</p>
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 2: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГО					
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: ХӨДӨЛМӨРИЙН АСУУДЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО					

<p>Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.</p>	<p>2.1.Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжин, тэнцвэрийг хангах</p>	<p>Батлагдсан эрх зүйн баримт бичиг</p>	<p>Хөдөлмөрийн асуудлыг Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиудаар зохицуулж байна.</p>	<p>Улсын төсөв, бусад эх үүсвэр</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга 1, Хөдөлмөрийн тухай хуулийг дагалдан 26 дүрэм, журам, аргачлал Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийг дагалдан 7 дүрэм, журам, аргачлал зэргийг батлуулсан байна.</p>	<p>- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан 20 дүрэм, журмыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Батлагдаагүй байгаа 6 журам нь салбар дундын шинжтэй болон хөдөлмөр, нийгмийн түншлэлийн талуудтай зөвшилцөх батлах шаардлагатай дүрэм, журам байна.</p> <p>Ковид-19 цар тахлын улмаас нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд бууралттай хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх нь аж ахуйн нэгж, байгууллагуудад ихээхэн хүндэл учруулах эрсдэлтэй байсан тул Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 6.2-ыг үндэслэн 2021, 2022 онд тус тус шинэчлэн тогтоогоогүй. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 550000 төгрөг байхаар, 2023 оны 10 дугаар сарын 12-ны 13 дугаар тогтоолоор 20 хувиар нэмэгдүүлэн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь цалин хөлсний хуваарилалтын хамгийн доод хэсэгт байгаа ажилчдыг хамгаалах зорилгоор тогтоосон цалингийн бүтцийн суурь давхаргын хамгийн бага хэмжээ гэж ОУХБ-аас тодорхойлсон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажиллагчдын хууль ёсны ашиг сонирхлыг</p>	<p>30</p>
---	--	---	---	-------------------------------------	---	---	-----------

						хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин /хөлс/-гийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаар юм гэж тодорхойлсон байдаг. Мөн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо 2024 оны 10 дугаар сарын 07-ны хуралдаанаар 2025 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэх тооцоолол, судалгааг хэлэлцэн, зөвшилцсөний үндсэн дээр улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	---	--

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ БОДЛОГО

Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ	2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний нэгдсэн стандартыг нэвтрүүлж, олон улсын жишигт нийцүүлэх	Үйлчилгээг нэвтрүүлсэн аймаг, нийслэлийн нэгж	2020 онд Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг 6 аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд	Улсын төсөв	Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн 31 нэгжид нэвтрүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох” зорилтын хүрээнд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн, ижил стандарт бүхий “Job center” төвүүдийг байгуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод 2024 онд эхний 4 төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн. “Job center” төвөөр үйлчлүүлсэнээр ажилгүй иргэн, ажил хайгч иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил, мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан залуучууд, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч иргэн, гадаадад амьдарч байгаад эх орондоо болон ажил олгогч байгууллагууд	30
--	--	---	--	-------------	---	--	----

			туршиж эхэлсэн байна.		<p>нэг дор хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг авах боломж бүрдэнэ. Мөн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандартыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар баталсан. Үйлчилгээний стандартын төслийг боловсруулахдаа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага MNS 6620:2016, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх заавар, аргачлал, улс орнуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх гарын авлага, зааварчилгаа, тус яаманд гадаад улсын санхүүжилтээр хэрэгжиж байсан олон улсын төслүүдийн санал, зөвлөмж болон бусад холбогдох баримт бичгүүдийг судлан боловсруулсан. Стандарт батлагдсантай холбогдуулан аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хувийн биржүүдийн ажилтнуудад 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр сургалт зохион байгуулсан.</p> <p>Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2025 онд Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Job center” төв байгуулах туршилтын төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү туршилтын төслийн хүрээнд 2025 онд төр-хувийн хэвшлийн түншлэлээр 10-аас доошгүй “Job center” төв байгуулах, Job center” төвд нийгмийн үйлчилгээг нэвтрүүлж, “Job center plus” үйлчилгээ үзүүлэх төв болгон өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх, туршилтын төсөлд хамрагдаж буй төвүүдийн үйл ажиллагааны менежментийг олон улсын жишигт нийцүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний стандартыг төр, хувийн</p>
--	--	--	--------------------------	--	--

						хэвшлийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд дагаж мөрдөнө.	
2.3. Хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг сайжруулж, тогтвортой ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлэх	Хамрагдсан хүний тоо	2020 онд хүн амын бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээнд 30547 иргэн хамрагдсан.		Нэг жилд 31 000 доошгүй иргэнийг хамруулсан байна.	Хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг сайжруулж, тогтвортой ажлын байрыг бий болгоход чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилласан. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөр арга хэмжээнд 2021-2024 онд нийт 69.6 тэрбум төгрөгийг төсөвлөж, 55.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 44455 иргэнийг хамруулсан байна. Үүнээс: - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021-2024 онд нийт 39.5 тэрбум төгрөг төсөвлөж 30.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 14839 иргэнийг хамруулсан. - Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд нийт 4.4 тэрбум төгрөг төсөвлөж 3.3 тэрбум төгрөгийг зарцуулж, 17747 иргэнийг хамруулсан. - Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд нийт 23.8 тэрбум төгрөг төсөвлөж 20.1 тэрбум төгрөгийг зарцуулж, 6710 иргэнийг хамруулсан Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд нийт 1.7 тэрбум төгрөг төсөвлөж 963.7 сая төгрөгийг зарцуулж, 5159 иргэнийг хамруулсан.	30	
2.4.Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа нарийн мэргэжлийн	Гадаад мэргэжилтний хувь	-		Гадаад мэргэжилтний 30 хувьд нь дотоодын ажиллах хүчийг	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасны дагуу “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” Засгийн	0	

	<p>өндөр ур чадвартай мэргэшсэн гадаадын мэргэжилтэнд дотоодын ажиллах хүчнийг дагалдуулан сургах</p>				<p>дагалдуулж мэргэшүүлсэн байна.</p>	<p>газрын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 359 дүгээр тогтоолоор 11 эдийн засгийн ангиллын 130 нарийн мэргэшлийн жагсаалтыг батлуулсан.</p> <p>Тогтоолын төслийг Монгол Улсад 2023-2025 онуудад шаардлагатай нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг аж үйлдвэрийн IV хувьсгал, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн динамик өөрчлөлт, олон улсын хөдөлмөрийн чиг хандлага болон өмнөх жилүүдийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажиллах хүчний статистик мэдээлэл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гадаадаас авч ажиллуулах зайлшгүй шаардлагатай нарийн мэргэшлийн мэрэгжилтний талаарх судалгаа зэрэгт тулгуурлан, холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын дэргэдэх 35 гаруй мэргэжлийн зөвлөлүүд, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон бусад оролцогч талууд, яамдын саналыг авч нэгтгэн боловсруулсан.</p> <p>Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг баталснаар уг жагсаалтад заасан мэргэшлийн гадаад ажилтанг авч ажиллуулахад Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.9-д заасан зөвшөөрлийг нэмэлт шаардлагагүй авах эрх зүйн орчин бүрдсэн.</p>	
<p>2.5.Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр</p>	<p>Шинээр ажилд орсон иргэдийн тоо</p>	<p>-</p>	<p>Улсын төсөв</p>	<p>-25000 шинэ ажлын байр бий болгосон байна.</p>	<p>Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, “Халамжаас-хөдөлмөрт” зорилтын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</p>	<p>100</p>	

	эрхлэлтийг дэмжих, “Халамжаас-Хөдөлмөрт” хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх					хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд, залуучууд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэн, малчин зэрэг зорилтот бүлгийн иргэдэд зориулсан хөтөлбөр, арга хэмжээнд 2021-2024 онд нийт 214.8 тэрбум төгрөг төсөвлөж, 172.8 тэрбум төгрөгийн зарцуулж, 119892 шинэ ажлын байр бий болгосон. Үүнээс 37009 байнгын ажлын байр бий болгосон байна.	
	2.6.Хөдөлмөр эрхлэлтийг сургалтын тэгш хүртээмжийг нэмэгдүүлэн, иргэдийн хөдөлмөр эрхлэх чадварыг дээшлүүлж насан туршийн суралцахуйг дэмжих	Батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо	“Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”	Чадамжийн санг 2022, 2023, 2024 онуудад үе шаттайгаар хөгжүүлэлт хийгдэнэ.	Бодлогын баримт бичиг 1 Журам 2 Чадамжийг кодлох аргачлал 1 Чадамжийн сан 2	“Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журам”-ыг Боловсролын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2024 оны А/29, А/04 тушаалаар баталж, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2024.02.26-ны өдөр бүртгүүлсэн. Мэргэжлийн сургалтын байгууллагад тавих шаардлагыг Боловсролын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2024 оны А/310, А/130 дугаар тушаалаар батлаж, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2024.07.08 өдөр бүртгүүлсэн.	30
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ БОДЛОГО							
<i>Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ</i>							
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг	2.7.Цалин хөлсний тогтолцоо, зохицуулалтыг боловсронгуй болгох	Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийн хувь	Төсөвт байгууллагын ажилтны сарын дундаж цалин 1053.4 мян.төгрөг	Улсын төсөв	Төрийн албан хаагчдын цалинг 10 хувиас багагүй хувь нэмэгдүүлсэн байна.	Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэн тогтоов. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын	100

нэмэгдүүлнэ						<p>үндсэн цалингийн доод хэмжээ 1.1 сая төгрөг (Суманд 1,540.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,320,0 мянган төгрөг), төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 900.0 мянган төгрөг (Суманд 1,260.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,080.0 мянган төгрөг) боллоо. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2024 оны 2 дугаар улирлын байдлаар нийт ажиллагчдын дундаж цалин хөлс 2,464.9 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс 2,417.3 мянган төгрөг байна.</p>	
	<p>2.8.Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолто д дүн шинжилгээ хийн шаардлагатай ажил мэргэжлийг нэмэх, өөрчлөх, шинэчлэх</p>	<p>Үндэсний ажил, мэргэжилийн ангилал ба тодорхойлолт</p>	<p>НХХС-ын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “ҮАМАТ-ын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 16 дугаар тушаал</p>	-	<p>ҮАМАТ-08-д нэмэлт, өөрчлөлт орсон байна.</p>	<p>ҮАМАТ-08-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх аргачлал”-ын дагуу тухай бүр (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар) нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой. Аргачлалд заасны дагуу аж ахуйн нэгж байгууллага нь шинээр нэмэх, өөрчлөх ажил мэргэжлийн саналаа салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагадаа гаргах, тухайн салбарын яам нь мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллага, нийгмийн түншлэгч талуудаар хэлэлцүүлсний үндсэн дээр саналаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлдэг. 2021-2024 онд нийт 247 ажил мэргэжлээр шаардлагатай нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 2021 оны А/208 тоот тушаалаар зам тээвэр, хүнс хөдөө аж ахуй, боловсрол, хүн ам, нийгмийн хамгааллын салбарт хамаарах 46 ажил, мэргэжлээр; 	100

					<ul style="list-style-type: none"> • 2022 оны А/143 тоот тушаалаар ажил зуучлалд өргөн хэрэглэгдэж байгаа 69 ажил, мэргэжлээр; • 2022 оны А/210 тоот тушаалаар барилга, хот байгуулалтын салбарт хамаарах 119 ажил, мэргэжлээр; • 2023 оны А/175 дугаар тушаалаар архив түүнтэй холбогдох 8 ажил, мэргэжлээр. • 2024 оны А/30 дугаар тушаалаар онцгой байдал, цэрэг, хамгаалалттай холбоотой 5 ажил мэргэжлээр тус тус нэмэлт, өөрчлөлт оржээ. <p>Дэлхийн банкны санхүүжилтээр YAMAT-08-д шаардлагатай сайжруулалт, өөрчлөлтийг тодорхойлох ажлыг зөвлөх үйлчилгээний хүрээнд хийлээ. Энэ хүрээнд ISCO-08-ын үндсэн, дэд, бага, нэгж бүлэг тус бүрийн нэршил, тодорхойлолтыг YAMAT-08-д хэрхэн орчуулан хэрэглэснийг харьцуулан судалсан. ISCO-08-ын нэгж бүлгийн кодыг үргэлжлүүлэн YAMAT-08-д одоогийн байдлаар 4242 үндэсний индекс/код бүхий ажил мэргэжлийг ангилсан байна. Гэвч ангилагдсан байгаа 4242 ажил мэргэжлийн тодорхойлолт, гол гүйцэтгэх чиг үүргийг оруулж өгөөгүй, зөвхөн ажил мэргэжлийн нэрээр индекс/кодыг баталсан нь ойролцоо чиг үүрэгтэй ажил мэргэжил давхардаж кодлогдох, ажлын чиг үүрэг, ажилбар бүрийг ажил мэргэжилтэй адилтган ангилсан байх, ажилд хэрэглэгдэх машин механизм, тоног төхөөрөмжийн төрөл, нэр бүрээр ажил мэргэжлийн үндэсний индекс/код үүсгэсэн байх зэрэг асуудлууд ажиглагдлаа. Монгол Улсын хувьд ISCO-08-ын 10 үндсэн бүлэг, 43 дэд бүлэг, 130 бага бүлэг, 431 нэгж бүлгийг авч хэрэглэсэн байна. ISCO-08-д байдаггүй нэмэлт 2 нэгж бүлгийг YAMAT-08 дээр шинээр нэмсэн, ISCO-08-ын 4 нэгж бүлгийг</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>хэрэглээгүй нь 2353 Өөр хэлний багш, 2354 Дуу хөгжмийн багш, 2355 Соёл урлагийн багш, 2656 Мэдээллийн технологийн сургагч гэсэн нэгж бүлгүүд байна.</p> <p>Нийт бүлгийн нэршил, тодорхойлолтыг үндсэн эхтэй нь тулган хянахад үндсэн, дэд, бага, нэгж бүлэгт нийт 44 өөрчлөлт, сайжруулалт хийх шаардлагатайг тодорхойлсон. Түүнчлэн YAMAT-08-ын удиртгал, арга зүйн хэсэгт оруулах засвар, өөрчлөлтийг гаргасан.</p> <p>YAMAT-ын нэршил, орчуулгыг бүхэлд нь дахин хянасан ажлын тайлан, саналд тулгуурлан YAMAT-08-ыг цахим хэлбэрээр гарын авлага байдлаар гаргахаар үндсэн материал дээр ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ны А/30 дугаар тушаалаар хууль сахиулах 5 ажил, мэргэжлээр нэмэлт өөрчлөлт орууллаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан YAMAT-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх аргачлалын дагуу Дотоод хэргийн их сургуулиас санал ирүүлсэн ажил мэргэжил бүрээр холбогдох мэдээллийг гарган, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдтэй зөвшилцсөн.</p>	
2.9.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талтын хамтын ажиллагааг бэхжүүлэх	Улсын хэлэлцээрийн хэрэгжилт хувь	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	-	Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн 90 хувьд хүргэсэн байна.	<p>Улсын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлууд хийгдэж, ажлын хэсэг байгуулах Үндэсний хорооны тогтоол, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох Ерөнхий сайдын захирамж, 2023-2025 оны Улсын хэлэлцээрийг амжилттай байгуулсан. 2023-2025 оны Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулан талуудад хүргүүлсэн болно. Улсын хэлэлцээрийн төлөвлөгөөний дагуу ажлууд хийгдэж байна. Үндэсний хорооны тогтоолоор хамтарсан ажлын хэсэг байгуулж, яамд холбогдох газруудаас ирсэн</p>	90

					<p>биелэлтийг нэгтгэн, талуудад тайланг хүргүүлэн ажиллаа. Улсын хэлэлцээрийн 2024 оны биелэлт 100% байна.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлуудыг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Засгийн газар салбарын хэлэлцээрүүдэд тусган хамтран ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу салбарын хамтын хэлэлцээрийг хянан бүртгэх, хуульд нийцээгүй тохиолдолд бүртгэхээс татгалзах эрхтэй.</p> <p>Одоогийн байдлаар салбарын 13 хэлэлцээрийг хуулийн дагуу хянан бүртгэсэн.</p>	
2.10.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, уялдаа холбоог нь сайжруулах	Батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байна. ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 3 конвенцид нэгдсэн.	-	Холбогдох хууль, дүрэм, журмын төслүүдийг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/173 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6562 дугаарт бүртгэсэн. Энэ хүрээнд сургагч багш нарыг шат дараатай бэлтгэн өнөөдрийн байдлаар нийт 247 сургагч багш бэлтгэгдсэн байна.</p> <p>Мөн Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын</p>	100

					<p>2023 оны А/155 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6518 дугаарт бүртгэсэн.</p> <p>Энэ хүрээнд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгч ажиллаж байна.</p> <p>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд бүртгэлтэй MNS ISO 17020 стандартын итгэмжлэлтэй, дараах 6 байгууллага ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж байна. Тус 6 байгууллагууд 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 120 аж ахуйн нэгж, байгууллагын 2684 ажлын байранд хэмжилт үнэлгээ хийж, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах тухай зөвлөмжийг хүргүүлсэн. -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг 2014 оноос эхлэн тодорхой салбарт зохион байгуулж, 2014-2021 онуудад эрсдэл өндөртэй салбар болох Барилга, Уул уурхай, Зам тээвэр, Эрчим хүч, Хөдөө аж ахуйн гэх мэт салбаруудад, 2021-2023 онуудад төрийн үйлчилгээний байгууллага болох Эрүүл мэнд, Боловсролын салбарт тус тус зохион байгуулсан. Үзлэгийн нэгдсэн дүнг ХАБЭА-н үндэсний хороонд танилцуулан, үндэсний хорооноос тухайн салбарт чиглэсэн зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>- 2024 онд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт</p>
--	--	--	--	--	---

					<p>оруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэг зохион байгуулах тухай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/841 тоот албан бичгээр ажлын удирдамж, чиглэлийг 21 аймаг 9 дүүрэгт хүргүүлсэн. Улсын үзлэгийн нэгдсэн дүнг УИХ-ын даргын 103 тоот захирамжаар байгуулагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүрхий ажлын хэсэгт танилцуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулсан.</p> <p>-Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний аргачлалын багц стандартыг шинэчлэн боловсруулах, батлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоотой хамтран MNS 5080:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих шаардлага, MNS 4990:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ, MNS 6999:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны бичил цаг уурын үзүүлэлтийн тохиромжтой хэмжээ, тэдгээрийг хэмжихэд тавих ерөнхий шаардлага гэсэн стандартуудыг шинэчлэн батлуулсан. Мөн 2024 онд Ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг</p>
--	--	--	--	--	---

						хамгаалахад мөрдөх техникийн зохицуулалт шинэчлэн боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын хурлаар танилцуулан батлуулсан. -ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны 187 дугаар конвенцод нэгдэн орох бэлтгэл ажлын хүрээнд дотоодын хууль тогтоомжийн нийцлийн судалгаа хийж, гарын авлага бэлтгэн боловсруулж, нийгмийн түншлэгч талууд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад танилцуулсан.	
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, аж ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	2.11.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, аж ахуйн нэгж байгууллагын түвшин дэх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтийг сайжруулах	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулсан хувь	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021 - 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.	-	Урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах замаар ҮОМШӨ-ийг 10-аас багагүй хувиар бууруулна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх 2025-2028 оны төлөвлөгөөг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/84 дугаар тушаалаар батлуулсан.	0
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 3: НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО							
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГО							

<p>Зорилт 3. Зорилтот иргэн, даатгуулагчид нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэж, нийгмийн баталгаагаар хангана.</p>	<p>3.1.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангасан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл хийх</p>	<p>Батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо</p>	<p>Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 26 удаа нэмэлт өөрчлөлт орсон.</p>	<p>-</p>	<p>Нийгмийн даатгалын багц 5 хуулийг шинэчлэн батлуулсан байна.</p>	<p>Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Засгийн газарт өгсөн. Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг дахин буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан үзэл баримтлалд нийцүүлэн дахин боловсруулж, Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна. Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл нь одоо мөрдөгдөж буй эв санааны нэгдлээс хуримтлалын тогтолцоонд шилжих, нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн</p>	<p>100</p>
--	--	---	---	----------	---	---	------------

					хэмжээтэй уялдаатай байх, мөн санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зэрэг зарчимд үндэслэн боловсруулж, шинэчлэлийн асуудлыг тусгав. Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах бусад хуулиудын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/3421 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэсэн. Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус хэлэлцэн баталсан.	
3.2.Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тогтоол, журам, дүрэм, заавар, аргачлалыг боловсруулж батлуулах	Батлагдсан эрх зүйн баримт бичиг	Хууль хэрэгжүүлэх явцад дүрэм журмыг өөрчлөх шийдвэрийн төслийг тухай бүрт боловсруулж батлуулдаг.	-	Тухай бүрд тогтоол, журам, дүрэм, заавар, аргачлалыг боловсруулж батлуулсан байна. Нийгмийн даатгалын багц хуулийг дагалдан гарах 72 дүрэм, журам, аргачлал, маягыг	Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль	100

				шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	<p>/шинэчилсэн найруулга/-ийг тус тус хэлэлцэн баталсан.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах, хуваарь батлах тухай” 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/176 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх журам, заавар, дүрэм, аргачлал боловсруулж батлуулах ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан УИХ-ын байнгын хороогоор батлуулж буй-2, Засгийн газрын тогтоолоор батлуулсан-13, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар батлуулсан - 9, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулсан-8, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бусад яамдтай /Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам/ хамтран баталсан-6, Нийгмийн даатгалын ерөнхий газрын баталсан-7, нэмэлтээр батлуулсан 5 дүрэм, журам тус тус байна. Нийт 67 дүрэм, журам батлагдахаас 2023 онд 49 дүрэм, журам батлагдаад байна.</p> <p>2024 онд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр батлуулсан дүрэм, журам, заавар: Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол-1, Засгийн газрын тогтоол-17, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол-17, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал-9, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал-4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаал-1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал-1, Нийгмийн даатгалын</p>
--	--	--	--	--	--

					<p>ерөнхий газрын даргын тушаал-7, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газрын хамтарсан тушаал-1 тус тус байна. Нийт 63 дүрэм, журам, зааврыг батлуулсан. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэхээр баталсан дүрэм, журам, заавруудыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны https://mfisp.gov.mn/content/detail/3137 цахим хуудсанд байршуулсан.</p>	
3.3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх	Тэтгэврийн нэмэгдлийн хувь	Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 300.0 мянган төгрөг, Дундаж тэтгэвэр-418.0 мянган төгрөг	-	Тэтгэврийн хэмжээг 15-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	<p>Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн 2021 оны хэрэглээний үнийн индексийн өсөлт (инфляцын түвшин)-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувьтай байсан.</p> <p>Иймээс тэтгэврийн худалдан авах чадварыг хэвээр хадгалах зорилгоор инфляцын түвшинтэй уялдуулан Засгийн газраас 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа бүх тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөгт, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр шийдвэрлэсэн. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 29.4 хувиар нэмэгдэж 547.2 мянган төгрөгт хүрсэн.</p> <p>Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дахин нэмэгдүүллээ. Үүнд:Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх ажлын хүрээнд дундаж цалин болон хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөд үндэслэн 2022 он суурьтай тэтгэвэр бодох цалингийн</p>	100

						<p>итгэлцүүрийг 2014 оноос хойш 9 жилийн дараа шинэчлэн баталж, ижил ажил мэргэжлээр ойролцоо жил ажиллаж, шимтгэл төлсөн тэтгэвэр авагчдын тэтгэврийн зөрүү ойртохоор боллоо. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээ 550 000 (таван зуун тавин мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440 000 (дөрвөн зуун дөчин мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 485.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 683.2 мянган төгрөгт хүрлээ.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох дундаж тэтгэвэр 787.5 мянган төгрөгт хүрсэн.</p>	
3.4.Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талууд (нийгмийн даатгалын салбарын ажилтан,	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Нэмэгдүүлсэн хамралтын хувь	Албан журмаар даатгуулагч-953.4 мянга Сайн дураар даатгуулагч-193.1 мянга Сайн дураар даатгуулсан	Албан журмын даатгуулагчийн тоог 5-аас багагүй хувиар, сайн дурын даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар	Албан журмын даатгуулагчийн тоог 5-аас багагүй хувиар, сайн дурын даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар	Монгол Улсын Их хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг баталсан. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 2 дугаар зүйл, 21 дүгээр зүйл, 22 дугаар	100	

	<p>албан хаагчид, ажил олгогч, иргэд, даатгуулагч)-ын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, хамралтыг нэмэгдүүлэх</p>		<p>малчдын тоо-58.5 мянга</p>	<p>нэмэгдүүлсэн байна.</p>	<p>нэмэгдүүлсэн байна.</p>	<p>зүйлд тус тус заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх ажил 2020 оны 04 дүгээр сараас эхэлж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болсон. Хуулийн дагуу 2020-2021 онд 38.9 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 579.9 мянган даатгуулагчид 873.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүллээ. Харин 2021 онд 44.0 тэрбум төгрөгийн торгууль, алдангиас чөлөөлсөн. -Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед үйл ажиллагааг нь зогсоосон, борлуулалтын орлого нь буурсан 7.2 мянган ажил олгогчийн 80.9 мянган даатгуулагчид ажилгүйдлийн даатгалын сангаас 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг олгосон.</p> <p>Энэхүү арга хэмжээний үр дүнд:</p> <p>Ажил олгогчийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • 2020-2021 онд 38.8 мянган ажил олгогчид санхүүгийн томоохон дэмжлэг болсон. • Ажлын байраа хадгалж, үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх боломж бүрдсэн. <p>Даатгуулагчийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • Даатгуулагчийн хувьд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа тасрахгүй байх, өрхийн орлогод дэмжлэг үзүүлэх, цар тахлыг хохирол багатай даван туулах боломжийг бүрдүүлсэн. • Хуулийн дагуу 2020-2021 онд 410.7 мянган албан журмын даатгуулагч, 169.2 мянган сайн дурын даатгуулагч нийт 579.9 мянган даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлсөн. Ингэснээр энэхүү чөлөөлөгдсөн дүнгээр даатгуулагчийн амжиргаанд дэмжлэг болсон. 	
--	---	--	-------------------------------	----------------------------	----------------------------	--	--

					<p>Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийг баталсан.</p> <p>Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулиар нэг сая ба түүнээс доош төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос албан журмаар болон сайн дураар даатгуулсан даатгуулагч 2022 оны 5-12 дугаар сард өөрийн хариуцан төлсөн шимтгэлийн 50 хувийг сар бүр буцаан авах эрхтэй болсон.</p> <p>Хуулийн хэрэгжилтийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийн буцаан олголтод 84.4 тэрбум төгрөгийг олгосон.</p> <p>Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуульд малчидтай холбоотой дараах онцлог зохицуулалтыг тусгасан. Үүнд:</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.23 дахь хэсэгт “Малчин, туслах малчин энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>хугацаа 5 жилээс ихгүй байна” гэж заасныг хэрэгжүүлж байна.</p> <p>Мөн Малчны өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад:</p> <p>-нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй,</p> <p>- нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. заасныг хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалд өмнөх онд 953.8 мянган албан журмын даатгуулагч хамрагдаж байсан бол 1161.3 мянган даатгуулагч албан журмаар хамрагдаж өмнөх оны мөн үеэс 18 хувиар, сайн дурын даатгалд 152.0 мянган хамрагдаж байсан бол 2024 оны 12 дугаар сарын байдлаар 171.3 мянган даатгуулагч сайн дураар хамрагдаж өмнөх оны мөн үеэс 11 хувиар тус тус өссөн байна</p>	
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОДЛОГО							
Зорилт 3. Зорилтот иргэн, даатгуулагчид нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэж, нийгмийн баталгаагаар хангана.	3.5.Зорилтот өрх, иргэдийн амьдралын нөхцөл, амьжиргааны түвшинг дээшлүүлэх оновчтой арга зам бүхий халамжийн бодлогын шинэчлэл хийх	Батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо	2012 оноос хойш хууль шинэчлэгдээгүй	-	Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг шинэчлэн холбогдох хууль, бодлогын баримт бичгийн төслийг батлуулсан байна.	Хуулийн төслийн боловсруулалт: Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгааг хийж, хуулийн төслүүдийн үзэл баримтлалын төслүүдийг боловсруулав. Хуулийн төслийг дагалдуулан 16 хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу	100

					<p>хуулийн төслийг үр нөлөөг үнэлэх үнэлгээ, зардлын судалгааг боловсруулсан болно.</p> <p>Үзэл баримтлал батлуулах:</p> <p>2021 он: Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж 12 дугаар сарын 03-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар хамтран батлуулсан.</p> <p>2024 он: Уг хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр ХНХ-ын сайд Х.Булгантуяа, Сангийн сайд Б.Жавхлан нар хамтран баталсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлахаар 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01/1077 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p> <p>Яамны бүтэц, чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Ажлын хэсэг Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан, тандан судалгааны хамт ХЗДХЯ-нд батлуулахаар сайдын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/1195 дугаар албан бичгээр хүргүүлж, 12 дугаар сарын 20-ны өдөр ГБХНХ-ын сайд Л.Энх-Амгалан, ХЗДХ-ийн сайд О.Алтангэрэл нар хамтран батлав.</p> <p>Хэлэлцүүлгүүд:</p> <p>Сангийн сайд, ХНХ-ын сайд болон холбогдох удирдлагын түвшинд 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Нийгмийн халамжийн шинэчлэлийг танилцуулсан.</p> <p>Түүнчлэн 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Нийгмийн халамжийн салбарын төв, орон нутгийн байгууллагын 900 гаруй албан хаагчид оролцсон сургалтад Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийг хэлэлцүүлж санал авлаа.</p>
--	--	--	--	--	---

					<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл болон Хүн амын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Ахмадын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ, Алдарт эхийн одонтой эхчүүдийн холбоо, төрөлсөн асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн болон ТББ зэрэг төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2021 оны 10 дугаар сарын 08-14-ний өдрүүдэд зохион байгуулж саналыг авч хуулийн төсөлд тусгалаа.</p> <p>Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх: Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/2831 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн ХЭГ/1996 дугаар албан бичгээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт орж, ЗГ-ын зарим гишүүд шинээр томилогдсонтой холбогдуулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн материалыг буцаан ирүүлсэн.</p> <p>Нийгмийн халамжийн салбарын бодлогод үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулсан. Энэхүү хуулийн төслийг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд, 2024 оны 11 сарын 22-ны өдөр УИХ-ын даргын зөвлөлд тус тус танилцуулж санал, зөвлөмжийг авч хуулийн төсөлд тусган ажиллав. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.27-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/58 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан.</p>
--	--	--	--	--	--

					<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу боловсруулсан.</p> <p>УИХ-д өргөн мэдүүлэх: Хуулийн төслийг УИХ-ын 2025 оны хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.</p>	
3.6.Нийгмийн халамжийн багц хуулийг хэрэгжүүлэх журам, дүрэм заавар, аргачлалыг боловсронгуй болгох	Батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо	Одоо мөрдөгдөж байгаа дүрэм, журмын тоо	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Батлагдсан хуулийг дагалдан гарах 22 дүрэм, журам, аргачлал, маягтыг шинэчлэн батлуулсан байна.	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэх журам, дүрэм заавар, аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх хүрээнд:</p> <p>Засгийн газрын тогтоол</p> <p>1.2021 оны 362 дугаар тогтоолоор "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам"</p> <p>2.2021 оны 363 дугаар тогтоолоор "Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ тогтоох тухай"</p> <p>3.2021 оны 199 дүгээр тогтоол "Журам батлах тухай "Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам"-ыг тус тус шинэчлэн батлуулсан.</p> <p>4.2023 оны 236 дугаар тогтоолоор "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам"</p> <p>5.2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 02 дугаар тогтоолоор "Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам"</p> <p>6.2024 оны "Журам шинэчлэн батлах тухай" 243 дугаар тогтоолын хавсралтаар "Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам", "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"</p> <p>7. 2024 оны "Журам батлах тухай" 245 дугаар тогтоолын хавсралтаар "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам"</p> <p>8.2023 оны "Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 237 дугаар тогтоол</p>	100

					<p>9.2024 оны “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 122 дугаар тогтоол</p> <p>10.2024 оны “Журам шинэчлэн батлах тухай”-244 дүгээр тогтоолын хавсралтаар “Насны хишиг олгох журам”</p> <p>11.2024 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 246 дугаар тогтоолоор “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>Сайд болон бусад сайд нарын хамтарсан тушаал:</p> <p>12. ГБХНХ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/76, А515 дугаар хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”</p> <p>13. ГБХНХ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/75, А/514 дүгээр хамтарсан тушаалаар “Ахмад үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус батлуулан Хууль зүй дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.</p> <p>14.2023 оны өдрийн А/188 дугаар тушаалаар “Төрөлжсөн асрамжийн газарт хамрагдаж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх журам”,</p> <p>15.А/189 дүгээр тушаалаар “Төрөлжсөн асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”,</p> <p>16.А/190 дүгээр тушаалаар “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэнд тэтгэвэр олгох журам”,</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>17.A/191 дүгээр тушаалаар “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журам”,</p> <p>18.A/130 дугаар тушаалаар “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний зардлын норматив батлах тухай” зэрэг 5 тушаалыг шинэчлэн батлуулж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.</p> <p>19. 2024 оны “Дүрэм шинэчлэн батлах урамшууллын хэмжээг тогтоох тухай” А/59 дүгээр тушаалаар “Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм, зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг тус тус шинэчлэн баталсан.</p> <p>20.2021 оны А/103 дугаар тушаал “Хүнсний эрхийн бичиг олгох журам”</p> <p>21.2021 оны “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт батлах тухай” А/807</p> <p>22.A/216 дугаар хамтарсан тушаал /Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох /</p>	
3.7.Зорилтот бүлгийг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх, аргачлалын дагуу амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд	Аргачлалын үр дүнд бүрдүүлсэн мэдээллийн сан	3 жил тутамд шинэчлэх аргачлал 2016 оноос хойш шинэчлэгдээгүй	-	Аргачлалыг шинэчлэн батлуулж, аргачлалын дагуу мэдээллийн санг бүрдүүлж ашигласан байна.	<p>Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хамтарсан А/84, А/89 тоот тушаалаар Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлуулсан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан нийт хүүхдийн 91 хувьд олгохтой холбоотой “Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-ыг боловсруулж Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/14, А/04 дүгээр хамтарсан тушаалаар баталсан юм. Уг</p>	100	

	<p>нэгдсэн удирдлагаар арга зүйгээр хангах</p>					<p>аргачлалын дагуу хүүхдийн мөнгийг 91 хувьд олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>Мөн түүнчлэн уг аргачлалын дагуу хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрхөөс судалгаа авах ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Энэ хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Орлогыг орлуулан тооцох аргачлал /ООТА/-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/36 дугаар тушаалыг батлуулсан. • Уг тушаалын дагуу судалгааг АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ийн батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахаар ажлын удирдамж, төсвийн тооцооллыг бэлтгэж, АХБ болон Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн. • ООТА-аар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 26,900 өрхийг хамруулан улсын хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр эхлүүлсэн. • Зөврийн төхөөрөмжид зориулсан судалгааны программыг үндсэн системийн хамт ашиглалтад оруулж, 21 аймаг, 9 дүүргийн ХХҮГ/ХХҮХ-ийн дарга, мэргэжилтэн болон судалгааны багийн гишүүдэд программ хангамжийн сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулав. Мэдээлэл технологийн ажилтнуудад rmt2022 систем болон түүний хэрэглэгчийн болоод судалгааны модулийн ашиглалтын сургалтыг 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар 5 удаа зохион байгуулсан. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд 26,900 өрхийн жагсаалтыг бэлтгэсэн. Өрхийн жагсаалтад орсон өрхүүдийг тоологчид хуваарилах болон газрын зурагт тэмдэглэх ажлуудыг хийлгэсэн. Судалгааны мэдээлэл 	
--	--	--	--	--	--	--	--

					<p>цуглуулах ажилтан болон багийн ахлагч/сургагч багшийн сургалтын бэлтгэлийг хангаж, сургалтыг 05 дугаар сарын 11-13-ны өдөр 70 хүнийг хамруулан, Улаанбаатар хотод танхимаар, тоологчийн сургалтыг аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь аймаг, дүүргийн хэмжээнд 5 дугаар сарын 21-23-ны өдөр 700 орчим тоологч, ахлагчийг хамруулж танхимаар (хувь зөвлөх цахимаар зөвлөж, чиглүүлж, зарим бүсэд дахин сургалт хийсэн) зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны урьдчилсан дүнгээр нийт хамрагдах өрхийн 99.1% хамрагдсан байгаа бөгөөд цаашид төрийн бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх ажил хийгдэж байна. • 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчилсэн аргачлалаар өрхийн амьжиргааг тооцон хүнсний дэмжлэг үзүүлэх өрхийг тодорхойлохоор ажиллаж байна. • 2020 онд Монгол Улсын ядуурлын түвшин 27.8 байсан бөгөөд энэ үед нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 409.679 ба түүнээс доош оноогоор тогтоож байсан. Харин 2022 онд Монгол Улсын ядуурлын түвшин 27.1 хувьтай байгаа тул түүнд харгалзах оноо буюу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 401.2 оноо болон түүнээс оноогоор тогтоох тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/97 тушаалыг батлуулан Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг 	
--	--	--	--	--	--	--

						<p>тодорхойлон хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Мөн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний оноог тодорхойлох зорилгоор өрхийн гишүүн-иргэний мэдээллийг ЭМДЕГ, ТЕГ, НДЕГ, ҮСХ зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг ХУР системээр дамжуулан авч өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлээд байна.</p>	
	<p>3.8.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх</p>	<p>Тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлийн хувь</p>	<p>2020 оны Тэтгэврийн хэмжээ-188.000 төг, Тэтгэмжийн хэмжээ-84.500 төг, 123.100</p>	<p>Улсын төсөв; 2022 онд 119.5 тэрбум.төг 2023 онд: 239.1 тэрбум.төг</p>	<p>Тэтгэврийн хэмжээг 15 хүртэлх хувиар нэмэгдүүлсэн байна.</p>	<p>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед зорилтот бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааг дэмжих зорилгоор 2020-2023 оны 7 дугаар сар хүртэл нийгмийн халамжийн тэтгэвэр 188 мянган төгрөгийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж олгосон.</p> <p>2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 12.8 хувиар нэмэгдүүлж 325,000 төгрөг, харин 2020 оноос хойш нэмэгдээгүй байсан асаргааны тэтгэмж 84,500 төгрөгийг 3 дахин нэмэгдүүлж 275,000 төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэний тэтгэмж 123,100 төгрөгийг мөн адил 275,000 төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн.</p> <p>Монгол Улсын 2024 оны төсөвт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 60.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг баталсан.</p> <p>Хүн амын амьжиргааны доод түвшиний өсөлт болон батлагдсан төсөвтэй уялдуулан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх хувилбар тооцооллыг хийж, халамжийн тэтгэврийг 15 хувь, асаргааны</p>	<p>100</p>

						<p>тэтгэмжийг 10 хувиар нэмэгдүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, уг тогтоолын төслийг 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 122 дугаар тогтоолоор батлууллаа. Энэ тогтоол батлагдсанаар нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 50 мянган төгрөгөөр нэмэгдэж 375 мянга, асаргааны тэтгэмжийн хэмжээ 10 хувиар нэмэгдэж 302.5 мянган төгрөгт хүрэв. Монгол Улсын 2025 оны төсөвт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 27.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг баталсан. Батлагдсан төсвийн эх үүсвэрт багтаан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар буюу 22.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сард олгох хэмжээг 397.5 мянган төгрөгөөр, байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээг 142.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн сард олгох хэмжээг 445.0 мянган төгрөг байхаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 247 дугаар тогтоолоор батлуулан 2025 оны 01 дүгээр сараас эхлэн олгох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	
3.9.Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтын платформ, хөтөлбөрийг боловсруулж, салбарын ажилтан,	Платформд байрлуулсан сургалтын модуль, болон түүнийг ашиглан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	-	ОУБ:80.0 мян.ам.доллар	Сургалтын платформ, хөтөлбөрийн дагуу салбарын ажилтнуудыг ажилласан жил, мэргэжлийн чиглэл, ур чадвар, хэрэгцээнд үндэслэн шаардлагатай	<p>Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд “Гөү Смарт” ХХК-тай гэрээ байгуулан хүний нөөцийг тасралтгүй сургах онлайн сургалтын платформыг худалдан авч Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2022 оны 10 дугаар сард хүлээлгэн өгсөн. Энэхүү платформыг ашиглан сургалтын агуулгыг тухайн байгууллагууд өөрсдийн онцлогт нийцүүлэн баяжуулж, нэмэгдүүлж, шинэчлэх боломжтой тул сургалт хариуцсан</p>	100	

	албан хаагчид, гэрээт төрийн бус байгууллагыг чадавхижуулах				сургалтад бүрэн хамруулж, мэргэшүүлсэн байна.	<p>нэгжид хариуцуулж ашиглалтыг эрчимжүүлэх талаар 2022, 2024 онуудад чиглэл хүргүүлж ажилласан. Уг чиглэлийг биелэлтийг ХХҮЕГ-ын 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 01/1582 дугаар албан бичгээр яаманд ирүүлсэн.</p> <p>Яамнаас өгсөн чиглэлийн дагуу:</p> <ul style="list-style-type: none"> • Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн байгууллагын албан хаагчдын судалгааг авч, нийт 1491 албан хаагчийг платформд бүртгэсэн. • Дэлхийн Банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Нийгмийн халамжийн салбарын ажилтнуудыг тасралтгүй сургах хүний нөөцийн онлайн модуль боловсруулах ажлыг Улаанбаатар ньус ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд тус байгууллагаас боловсруулсан 6 үндсэн багц сэдвийн /1. Нийгмийн халамжийн түүх, бодлого хэрэгжилт, 2. Хувь хүний хөгжил стресс менежмент, 3. Нийгмийн ажлын удирдлага, 4. Үр дүнтэй нийгмийн халамжийн тогтолцоо, Нийгмийн халамжийн цахим шилжилт, 5. Ядуу өрх, иргэнтэй ажиллах төгсөлтийн аргачлал, 6. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох орлогыг орлуулан тооцох шинэ аргачлал/ онлайн сургалтын контент, гарын авлага, материалуудыг боловсруулж, сургалтын платформд байршуулсан. • 2024 онд Нийслэлийн халамжийн үйлчилгээний газартай хамтран салбарын шинэ ажилтныг чадавхижуулах 3 модуль сургалтын 	
--	---	--	--	--	---	--	--

						<p>хөтөлбөрийг боловсруулж, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст шинээр томилогдсон албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын платформд Удирдлагын академийн багш Т.Жаргал, Т.Төмөр нарын “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах нь”, “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх” сэдэвт сургалтын хичээл, Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албан хаагчийн ёс зүй, бодлого, үйл ажиллагаа”, ҮСХ-ны салбарын албан хаагчдад зориулсан Stata программын сэдэвт сургалтын хичээлүүдийг байршуулсан. • Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалтын хүрээнд Халамжийн нэгдсэн систем хэрэглэгчдийн систем ашиглах мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 1 гарын авлага, 12 видео хичээлийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. • Халамжийн нэгдсэн системд орон нутгийн төсөвтэй үйлчилгээнүүдийн гүйлгээг төрийн сан руу илгээх талаар 21 аймаг, 9 дүүргийн 31 халамжийн сангийн ахлах мэргэжилтнүүдэд цахимаар сургалт зохион байгуулж арга зүйгээр хангаж ажиллалаа. • ADB-ны зөвлөхүүдийн гүйцэтгэсэн халамжийн тайлангийн системийг хэрхэн ашиглах, тайлан гаргах, халамжийн нэгдсэн системтэй тулгах талаар 21 аймаг, 9 дүүргийн Олголт
--	--	--	--	--	--	---

						<p>хариуцсан мэргэжилтнүүдэд цахимаар сургалт байгуулж сургалтад нийт 31 албан хаагч хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, мэдээллийн технологийн төвийн зөвлөхүүдтэй хамтран 2024 оны 04 сарын 02-ны өдөр аймаг, дүүргүүдийн статистик тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг цахимаар зохион байгуулж сургалтанд нийт 65 мэргэжилтнүүд хамрагдсан болно. Сургалтын гарын авлага, мэдээ тайлангийн маягтуудыг сургалтын платформ ашиглан гарын авлага болгон байршуулсан. Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрт хамрагдсан өрхтэй ажиллаж байгаа хүний нөөцийг чадавжуулах хүрээнд СХД, ЧД, БЗД-ийн 45 хорооны Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: Төгсөлтийн аргачлалын Модуль 3 “Нийгмийн хамгаалал” Модуль 4 “Санхүүгийн оролцоо” сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг сургалтын үр дүнд төгсөлтийн аргачлалын үндсэн тулгуур багана болох “Нийгмийн хамгаалал”, “Санхүүгийн оролцоо”-ны талаарх мэдлэг, ойлголттой болохоос гадна асуудлын хүрээнд зорилтот өрхтэй ажиллах чадавхид суралцаж, арга
--	--	--	--	--	--	---

						<p>хэмжээг хэрэгжүүлэх, өрх төгсөх шалгуурын талаар мэдээлэлтэй болсон байна. Мөн өрхийг бүлэг болгон нийгэмшүүлэх, бүлгээр дамжуулан өрхийн дасгалжуулалтыг болон өрхийн санхүүгийн боловсролыг хэрхэн олгох ур чадварыг нэмэгдүүллээ.</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Төрөлжсөн асрамжийн үйчилгээний цахим систем”-ийг хөгжүүлэн 2024 оны 04 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд улсын болон орон нутгийн өмчийн 12 асрамжийн газрын 37 ажилтан, албан хаагчид систем ашиглалт, нэвтрүүлэлтийн чиглэлээр сургалт зохион байгуулж ажиллалаа. Энэхүү систем нэвтэрснээр иргэн асрамжийн газарт асруулах хүсэлтээ цахимаар гаргах боломж бүрдэхээс гадна, төрөлжсөн асрамжийн байгууллагуудын танилцуулга, статистик тоо, төсөв, санхүүгийн мэдээллийг багтаасан томоохон мэдээллийн сан бүрдэх юм. • ВЭБ-д суурилсан дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны системийг нэвтрүүлэх ажлыг 2022 оноос хэрэгжүүлж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон харьяа аймаг, дүүргийн 30 хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж, киоск машиныг 2023 онд суурилуулж байршуулсан. <p>Уг системийг хэрхэн ажиллуулах талаар заавар, зааварчилгаа, гарын авлагыг тус газрын Мэдээлэл технологийн төв боловсруулж, онлайн сургалтын платформд байршуулж, онлайн сургалтыг зохион</p>
--	--	--	--	--	--	--

					<p>байгуулсан. Энэхүү системийг ашигласнаар 21 аймаг, 9 дүүрэг, 342 сум, 204 хороодод хөдөлмөр, халамжийн үйлчилгээг биечлэн авсан иргэд QR код, гар утасны мессэж, киоск машиныг ашиглан тухайн ажилтны үзүүлсэн үйлчилгээг үнэлгээний 5 түвшинээр үнэлэх ба үнэлгээний үр дүнг холбогдох байгууллагуудын вэб сайтад байршуулж харах боломж бүрдсэн.</p> <p>Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын судалгааг авч, нийт 1974 албан хаагчийг платформд бүртгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> • 2024 оны 01 дүгээр сарын 08-нд “Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан сургалт, уулзалтыг 3 сэдвийн хүрээнд зохион байгуулж сургалтын файлыг Динамик платформд байршуулсан. • Сургалтын динамик платформд Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлтэй хамтран “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан тушаал -Шинэ заалт хүргэх тухай” цахим сургалт зохион байгуулж сургалтын видеог динамикт байршуулсан. •2024 оны 01 дүгээр сард Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хөрөнгө оруулалтын газартай хамтран Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төвлөрүүлэлтэй холбоотой цаг үеийн асуудлаар салбарын хэмжээнд цахим уулзалт зохион байгуулсан. Уг цахим уулзалтын видеог динамикт байршуулсан. •“Гөү Смарт” ХХК-тай хамтран Сургалтын Динамик платформ программын сургалтыг 4 сэдвийн хүрээнд зохион байгуулж, Аймаг, дүүргийн сургалт хариуцсан мэргэжилтэн нарт админ эрх олгосон. •2024 онд Нийгмийн даатгалын систем шинэчлэгдсэнтэй холбоотойгоор салбарын албан хаагчдад сургалтын динамик 	
--	--	--	--	--	--	--

					<p>платформд үе шаттайгаар сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: “Шимтгэлийн тайлан илгээх зааварчилгаа”, “Тэтгэмжийн тогтоолт”, “Зөрчил дэд системд нөхөн тайлан бүртгэх” гэх мэт.</p> <ul style="list-style-type: none"> •2024 оны 2 дугаар улиралд НДЕГ, Мэдээлэл технологийн төвтэй хамтран “Ажил олгогчийн цахим систем” сэдэвт сургалтыг 3 сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Сургалтын файл болон видеог динамик платформд байршуулсан. •Монгол бичгийн дунд шатны цахим сургалтыг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд динамик платформуор зохион байгуулсан. Нийт 10 удаагийн цахим хичээлийн видеог динамик платформд байршуулсан. •E-mongolia academy-тай хамтран албан бичиг солилцооны дундын систем “DOCX”-ийн цахим сургалт зохион байгуулж видеог динамикт байршуулсан. •Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын гэмт хэрэг” сэдэвт сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтын видео болон хичээлийн файлыг динамикт байршуулсан. •Архивын ерөнхий газартай хамтран “Архив, албан хэрэг хөтлөлтийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх” сургалтыг цахим болон танхимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулан, сургалтын видео болон хичээлийн файлыг динамикт байршуулсан. •Нийгмийн даатгалын улсын байцаагчийг шалгалт өгөх албан хаагчдад зориулж 11 удаагийн цахим сургалтыг динамик платформ ашиглан зохион байгуулж сургалтын видео болон хичээлийн файлыг динамикт байршуулсан. 	
3.10.Нийгмийн халамжийн хууль	Нийтлэл, нэвтрүүлэг, ярилцлага	-	-	Нийтлэл, нэвтрүүлэг, ярилцлага шторк	2022 онд Нийгмийн халамжийн тогтолцооны өнөөгийн байдал, хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар иргэд, олон нийтийн	100

	<p>тогтоомжийн талаар иргэд, олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах зорилгоор мэдээлэл, сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>шторк г.м сурталчилгааны тоо</p>			<p>бэлтгэж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн байна.</p>	<p>ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Монгол HD телевизтэй хамтран хийсэн 2 нэвтрүүлэг, 1 ярилцлага, 4 шторкийн агуулгыг бэлтгэн нэвтрүүлгийн агуулга, ярианы сэдэв, оролцогсдын жагсаалтыг бэлтгэн, оролцогсдыг яриа өгөх цагийн хуваарь, орчин нөхцөлийг бүрдүүлж өгч ажиллав. Зураг авалтыг 2022 оны 04 дүгээр сарын 11-18-ны өдрүүдэд хийж, сайд, дэд сайд, БТГ-ын дарга, мэргэжилтнүүд, өрх, иргэд, дүүрэг, агентлагийн дарга, мэргэжилтнүүд бэлтгэсэн агуулгын хүрээнд яриа мэдээлэл өгч хамтран ажиллав. Монгол HD телевизээр 2022 оны 6-р сарын 04, 11-нд “Халамжийн бодлого ба шинэчлэл” ярилцлага, 06 дугаар сарын 05, 11-нд “Халамж” өнөөгийн нөхцөл байдал нэвтрүүлэг, 06 дугаар сарын 18, 25-нд “Халамжийн шинэчлэл” нэвтрүүлгийг тус тус цацав.</p> <p>2023 онд цахимжсан үйлчилгээний талаар шторк, зурагт хуудас, гарын авлагын нэмэлт өөрчлөлтийг ГТСМТТ-тэй хамтран боловсруулж, Нийгмийн халамжийн нэгдсэн систем (ehalamj)-д байршуулан, хэрэглэгчдэд /иргэд болон, албан хаагчдад/ нээлттэй байдлаар байршуулсан.</p> <p>Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91 хувьд олгож байгаатай холбоотой Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/, Нийгмийн халамжийн нэгдсэн систем /ehalamj/, -ээр дамжуулан өрхийн мэдээллээ засуулах, шинэчлэх, хүсэлт гаргах, өрхийн амьжиргаа үнэлүүлэх заавар хүргэх видео шторкыг бэлтгэж, түгээж ажилласан бөгөөд түгээмэл асуулт, хариултууд бэлтгэн байрлууллаа.</p> <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Нийгмийн халамжийн 5 багцын 22 төрлийн нийт 35 минутын шторкыг</p>
--	---	-------------------------------------	--	--	--	---

						<p>бэлтгэн байгууллагын болон аймаг, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн цахим хуудсан байршуулан олон нийтэд түгээсэн.</p> <p>2024 онд “Нийгмийн халамжийн шинэчлэл”, “Нийгмийн халамжийн өнөөгийн байдал, шинэчлэл” гарын авлага, Монгол Улсад ахмадын асрамжийн байгууллага үүсэж, хөгжсөний 100 жилийн ойд зориулан “Нийгмийн халамжийн түүхэн хөгжил” номын агуулгыг тус тус боловсруулан, газрын дарга удирдлага хянаж, эцэслэн сонгогдсон хэвлэлийн компанид хэвлүүлэхээр хүргүүлсэн.</p> <p>2024 онд Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Нийгмийн халамжийн нэгдсэн систем (ehalamj)-ийн танилцуулга”, “Нийгмийн халамжийн нэгдсэн систем (ehalamj)-ээр “0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж”-д хамрагдах танилцуулга” чиглэлээр видео шторкын ажлын даалгавар боловсруулсан. Уг ажлыг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх бөгөөд “Жилкер туульч ТББ”-ыг сонгон шалгаруулан гүйцэтгүүлсэн.</p> <p>Уг байгууллагаас “Ehalamj системээр авах үйлчилгээний тухай” 2 минут, “0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авах хүсэлт хэрхэн гаргах тухай” 2 минут шторк бэлтгэсэн. Уг шторкыг Ehalamj систем болон яам, агентлаг, орон нутгийн халамжийн байгууллагын пэйж хуудсанд байрлуулж олон нийтэд түгээсэн.</p>	
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 4: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ХАНГАХ, САЛБАРЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ							
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын удирдлага, манлайллыг төгөлдөржүүлнэ.							
4.1.Хүний нөөцийг	Төрийн албан хаагчийн	ХНХЯ-ны төрийн албан	Улсын төсөв	Төрийн албан хаагчийн	2022 онд:	90	

<p>Зорилт 4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын удирдлага, манлайллыг төгөлдөржүүлнэ.</p>	<p>чадавхжуулж, хөгжүүлэх замаар салбарын үйл ажиллагааг сайжруулах</p>	<p>сургалтын хөтөлбөр</p>	<p>хаагчийн “Сургалтын төлөвлөгөө”-г ЗГХЭГ, Удирдлагын академийн 2020 оны сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж 55 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулж, 5 сургалтыг зохион байгуулсан.</p>	<p>ОУБ-ууд, төсөл хөтөлбөрийн санхүүжилт</p>	<p>сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллав. -Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолын дагуу сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулав. -Удирдлагын академиас зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Төрийн албанд шинээр томилогдсон алба хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, Төрийн албанд Анх томилогдсон албан хаагчийн чиглүүлэх богино сургалтад 8, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 6 , “Албан хэрэг хөтлөлт” богино хугацааны зайн сургалтад 1 албан хаагч, "Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг" сургалтад 2, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад 5, “Систем сэтгэлгээ” сургалтад 2, “Дизайн сэтгэлгээ” сургалт 2, “Зан үйлийн нөлөөлөл” сургалтад 2 албан хаагчдыг тус тус хамруулсан -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Бүгд Найрамдах Турк улсын эрдэмтэн судлаач нартай хамтран “Төрийн албаны манлайлал, шинэ менежмент” сэдэвт сургалтыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, харьяа агентлагын удирдлах албан тушаалтнууд болон албан хаагчдад 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 10 давхрын хурлын</p>
---	---	---------------------------	---	--	--	---

					<p>танхимд зохион байгуулж сургалтад нийт 107 албан хаагч хамрагдсан.</p> <p>-Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх төслийн хүрээнд “Төрийн албан хаагчийн шударга зарчимч байдлыг нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтын яамны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад зориулсан сургалтыг төслийн багтай хамтран зохион байгуулсан.</p> <p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон дунд хугацааны “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилтыг төрийн албан хаагчдад таниулан сурталчлах Удирдлагын академийн сургалтад ХНХ-ын салбарын 100 албан хаагчдыг 2022 оны 09 дүгээр сарын 19-27-ны өдрүүдэд удирдлагын академийн сургалтын багтай хамтран зохион байгуулсан.</p> <p><u>2023 онд:</u> ХНХЯ-наас өөрийн үйл ажиллагаагаа сайжруулахын тулд тасралтгүй суралцаж, суралцах шинэ арга барилыг идэвхтэй хэрэглэдэг “Суралцагч байгууллага” болон төлөвших зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2023 онд мэргэшүүлэх сургалтад хамрагдах албан хаагчдын тооцоо судалгааг салбарын хэмжээнд гаргасан бөгөөд Тэргүүн түшмэлийн сургалтад 1, Эрхэлсэн түшмэлийн сургалтад 7, Ахлах түшмэлийн сургалтад 29, дунд хугацааны давтан сургалтад 10, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад 10 нийт 56 албан хаагчийг суралцуулсан байна.</p> <p>Нийт албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээг хангах иж бүрэн тогтолцоо бий болгон яамны эрхлэх асуудлын хүрээнд 30 гаруй албан хаагч</p>
--	--	--	--	--	--

					<p>гадаадад улсад богино хугацааны сургалтад хамрагдсан байна.</p> <p>Мөн Төрийн албаны зөвлөлөөс 2023 онд зохион байгуулсан Пүрэв гарагийн Вэбинар сургалтад Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга гишүүд, Харьяа байгууллагын Захиргаа удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, хүний нөөцийн ажилтан, холбогдох албан хаагчдыг хамруулах ажлыг тухай бүх зохион байгуулж ажилласан.</p> <p>Төрийн албан хаагчдыг хөгжүүлэх ажлын хүрээнд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төрийн албан хаагчийг Япон улсын их дээд сургуулийн магистр, докторын түвшинд суралцуулдаг “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийн магистрын сургалтад хамрагдсан 3 албан хаагчтай гурвалсан гэрээ байгуулж, суралцах хугацаанд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн дагуу төлж байна.</p> <p>Нийт албан хаагчдад ажлын байран дахь эерэг зөв хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, хүмүүс хоорондын харилцааг дэмжих, харилцан ойлголцох нөхцөл байдлыг бүрдүүлэх, хамтын ажиллагааны дэвшилттэй арга барил, арга хэрэгсэл бий болгох, хүмүүс хоорондын харилцааг идэвхжүүлэх уур амьсгалыг эрүүлжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх чиглэлээр төлөвлөгөөний дагуу сургалтуудыг Мэдээллийн цагаар сар бүр зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>2024 онд:</p> <p>Албан хаагчдын мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангахын тулд сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаа авч, албан хаагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтуудыг оновчтой зохион байгуулах ажлыг төлөвлөн ажиллаж байна. ХНХЯ-ны 2024 оны</p>
--	--	--	--	--	---

						<p>“Сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан батлуулсан бөгөөд албан хаагчдыг шатлан дэвшиж ажиллахад шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд албан хаагчийг ахлах болон эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад байгууллагын зардлаар болон улсын төсвийн санхүүжилтээр хамруулах хүсэлт хүргүүлсэнээс эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6 албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 15 албан хаагч, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагчийг хамруулан суралцуулахаар гэрээ байгуулан ажиллалаа. Мөн цаг үеийн шаардлагад нийцсэн мэдлэг, мэдээллийг олгох үүднээс албан хаагчдыг богино хугацааны зорилтот сургалтад хамруулах ажлыг Төрийн албаны зөвлөл болон Удирдлагын академитай хамтран зохион байгуулж ажиллаж байна. Тайлант хугацаанд яамны 49 албан хаагч эрхэлсэн чиг үүргийн хүрээнд гадаад улсад зохион байгуулагдаж буй сургалтад хамрагдаж, гадаад улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд сургалт, хөтөлбөрт хамруулахаар холбогдох байгууллагуудад албан хаагчдын нэрийг дэвшүүлж шаардлагатай материалыг хүргүүлж ажиллалаа.</p>	
4.2.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах замаар салбарын албан	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг	Улсын төсөв	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2024)-ийг батлан,	2022 он: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2022.01.15-ны өдөр батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллав. Үүнд:	90	

	<p>хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, мэргэшэх, мерит зарчмаар шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>хангах хөтөлбөр /2021-2024/-ийг батлан, хэрэгжилтийг хангах</p>	<p>хангах хөтөлбөр /2016-2020/ хэрэгжүүлсэн.</p>		<p>хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>-Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолын дагуу сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулав.</p> <p>-Удирдлагын академиас зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Төрийн албанд шинээр томилогдсон алба хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, Төрийн албанд Анх томилогдсон албан хаагчийн чиглүүлэх богино сургалтад 8, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 6 , “Албан хэрэг хөтлөлт” богино хугацааны зайн сургалтад 1 албан хаагч, "Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг" сургалтад 2, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад 5, “Систем сэтгэлгээ” сургалтад 2, “Дизайн сэтгэлгээ” сургалт 2, “Зан үйлийн нөлөөлөл” сургалтад 2 албан хаагчдыг тус тус хамруулсан</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Бүгд Найрамдах Турк улсын эрдэмтэн судлаач нартай хамтран “Төрийн албаны манлайлал, шинэ менежмент” сэдэвт сургалтыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, харьяа агентлагын удирдлах албан тушаалтнууд болон албан хаагчдад 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 10 давхрын хурлын танхимд зохион байгуулж сургалтад нийт 107 албан хаагч хамрагдсан.</p> <p>-Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх төслийн хүрээнд “Төрийн албан хаагчийн шударга зарчимч</p>
--	---	--	--	--	-------------------------------------	--

					<p>байдлыг нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтын яамны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад зориулсан сургалтыг төслийн багтай хамтран зохион байгуулсан.</p> <p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон дунд хугацааны “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилтыг төрийн албан хаагчдад таниулан сурталчлах Удирдлагын академийн сургалтад ХНХ-ын салбарын 100 албан хаагчдыг 2022 оны 09 дүгээр сарын 19-27-ны өдрүүдэд удирдлагын академийн сургалтын багтай хамтран зохион байгуулсан.</p> <p>2023 он:</p> <p>Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах хүрээнд:</p> <p>Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллын уян хатан, ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэхээр зорин ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 2023 оны хагас жилээр 144 хүнд 536,6 сая төгрөгийг урамшуулалд олгосон байна.</p> <p>Ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн шахуу хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн илүү цагаар ажилласан албан хаагчдад цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг тооцож олгох Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын дагуу 17 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 5.1 сая төгрөгийг тооцож олголоо.</p> <p>Дэвшилтэт шинэ технологийг ажилдаа нэвтрүүлэх, цаасгүй технологийг бий болгох хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, хяналт, удирдлагын цогц онлайн Abble системийг ашиглаж эхлээд байна.</p> <p>Ажпын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн офиссын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.</p> <p>Ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн, албан хаагчдаас ажил үйлсээрээ бусдыгаа хошуучлан ажиллаж байгаа 1 албан хаагчийг Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 5 албан хаагчийг Алтан гадас одонгоор, 8 албан хаагчийг Хөдөлмөрийн хүндэт медалиар, 1 албан хаагчийг Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр, 2 албан хаагч төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр, 9 албан хаагчийг Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр, 3 албан хаагчийг Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр, 6 албан хаагчийг Яамны хүндэт жуух бичгээр тодорхойлон шагнуулсан байна.</p> <p>Засгийн газраас гаргасан "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийн хүрээнд яам өөрийн байрандаа ажилчдынхаа хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулж ажиллуулж байгаа бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд 37 дугаар цэцэрлэгийн салбар цэцэрлэгт 35 хүүхэд хүмүүжиж байна.</p> <p>Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд байгууллагаас олгох, тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэх хүрээнд:</p> <p>Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл орон сууцаар хангах, ажилтнуудын нийгмийн</p>
--	--	--	--	--	--

					<p>баталгааг хангах асуудлыг Төрийн албаны хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг яамны төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Төрийн албан хаагчдын хэрэгцээнд үндэслэн орон сууцны болон нөхцөлийг нь сайжруулах асуудлыг судлан, Төгс орчин ХХК-тай Хан-уул дүүргийн Буянт ухаа спорт цогцолбор, Буянт ухаа нисэх буудал 2-ын дунд төв замаас 100м зайд барих 196 айлын орон сууцанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр захиалгад хамруулах гэрээ байгуулж, захиалга өгөх албан хаагчдын судалгааг гарган, 13 ажилтан урьдчилгаа төлж, гэрээ байгуулсан.</p> <p>Төрийн албан хаагчдын хэрэгцээнд зуслангийн зориулалтын газар эзэмших, ашиглах, байшин барихад дэмжлэг үзүүлэн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Кувейтын аманд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдын амины хэрэгцээнд зуслангийн зориулалтын газар эзэмших, ашиглах зөвшөөрөл авч, кадастрын зураг хийлгэхээр дүүргийн Газрын албатай хамтран ажиллаж байна.</p> <p>Төрийн албан хаагчдын нийгмийн батлагааг хангах хүрээнд төрийн албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдрийн 3,0 мянга, өдрийн хоолны мөнгөнд 12,0 мянган төгрөгөөр тооцон, сар бүр олгож байна.</p> <p>Мөн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинээр гэр бүл болсон 1 ажилтанд 500,0 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал гарсан 9 ажилтанд 2.7 сая төгрөг, өөрийн зардлаар мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр их дээд сургуульд суралцаж байгаа 11 ажилтанд 5.5 сая төгрөг, шинээр байранд орсон 14 албан</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>хаагчид 7.0 сая төгрөг, шинээр төрсөн хүүхэдтэй 3 ажилтанд 900,0 мянган төгрөг, 2023 оны шилдэг 11 ажилтанд тус бүр 1,0 төгрөгийн нийт 50 ажилтанд 32,2 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч болон албан хаагчийн гэр бүлд байнгын асаргаатай хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг бол тухайн албан хаагчийн ажлын цагийг богиносгох зохицуулалтыг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд оруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд:</p> <p>Төрийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг жил бүр мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Энэ жилийн хувьд Хавдар судлалын Үндэсний төвтэй гэрээ байгуулан, албан хаагчдаа урдчилан сэргийлэх багц шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байгаа ба үзлэг, судалгааны дагуу төрийн албан хаагчийг системтэйгээр эмчлүүлэх, сувилуулах ажлыг хийхээр ажиллаж байна.</p> <p>Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг дэмжин, яамны албан хаагчдаа Улсын хоёрдугаар төв эмнэлэгт эрт илрүүлгийн оношлогоо, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, нийт 128 албан хаагч оролцлоо.</p> <p>2024 он:</p> <p>Төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж</p>	
--	--	--	--	--	---	--

						байна. Энэ оны эхний хагас жилд Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 2024 оны эхний хагас жилээр 144 албан хаагчид холбогдох журмын дагуу урамшуулал олгосон байна. Ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн шахуу хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн илүү цагаар ажилласан албан хаагчдад цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг тооцож олгох Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу 10 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 3,5 сая төгрөгийг тооцож олголоо. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд төрийн албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдрийн 3 мянга, өдрийн хоолны мөнгөнд 25 мянган төгрөгөөр тооцон, сар бүр олгохоор өөрчлөлт орж, эхний хагас жилд 249,1 сая төгрөг олгосон байна. Мөн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинээр гэр бүл болсон 1 ажилтанд 800 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал гарсан 9 ажилтанд 5.6 сая төгрөг, өөрийн зардлаар мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр их дээд сургуульд суралцаж байгаа 3 ажилтанд 2.4 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон	
4.3. Байгууллагын гүйцэтгэлийн тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах,	Цахим системийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах,	Цахим систем байхгүй.	Улсын төсөв	Эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан	Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим системийг байгууллагын гүйцэтгэлийн	2022, 2023 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу цахим систем нэвтрүүлэх ажлыг хойшлуулсан. Дотоод удирдлагын “ABLE”, “ERP” системийг 2024 оноос нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн бөгөөд гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим	30

	тайлагнах арга хэмжээнд шинэ технологи нэвтрүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгох	тайлагнах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагаанд нэвтрүүлэх		санхүүгийн боломжтой үед нэвтрүүлнэ.	төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	системийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагаанд 2025 оноос нэвтрүүлэхээр ажиллаж байна.	
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: САЛБАРЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАТИСТИК, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ							
Зорилт 5. Цахим шилжилтийг гүнзгийрүүлж, үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ил тод нээлттэй хүргэнэ.							
Зорилт 5. Цахим шилжилтийг гүнзгийрүүлж, үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ил тод нээлттэй хүргэнэ.	5.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, урьдчилан сэргийлэх зөвлөгөөг цахимаар өгдөг болох	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн санд холбогдсон хамгаалах байрны тоо, Урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл авсан иргэдийн тоо	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн программын хөгжүүлэлтийг хийсэн. Иргэд, олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөө өгөх, хэрэглэгчийн программ хөгжүүлэлтийг хийсэн байна.	Төсөв: 100,0 сая төгрөг	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн тохиолдол бүрийг бүртгэлжүүлсэн байна. Анхан шатны бүх үйлчилгээг нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, хяналт, хариуцлагын удирдлагын тогтолцоог сайжруулсан байна.	Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх цахим сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхээр ГБХЗХГ-ын даргын 2022 оны А/81 тушаалаар “Блэйнд кэйр” компанитай 19/2022 тоот гэрээ байгуулан иргэдэд үнэ төлбөргүй сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлсэн. Нийт 4192 хүнд үнэ төлбөргүй зөвлөгөө өгснөөс 3350 эмэгтэй, 842 эрэгтэй хандаж, нийгмийн асуудлаас үүдсэн сэтгэл зүйн асуудал, гэр бүлийн харилцаа, хувь хүний харилцаа зэрэг асуудлаар зөвлөгөө авсан. 2024 онд онцгой нөхцөл байдлын үнэлгээ болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нэмэлт цэс, түр дугаар 95951622 нээж 108 насанд хүрэгч, 48 хүүхдийг зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагатай хамтран Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн үйлчилгээний бүртгэл, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчлүүлэгчдийн бүртгэл гэсэн 2 модуль бүхий “Хохирогч иргэдийн мэдээллийн систем”-ийг нэвтрүүлэн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 39 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчлүүлэгчийг бүртгэх, кейс нээх, үйлчилгээг хүргэх, кейс хаах, шилжүүлэх,	100

						тайлан боловсруулах боломжтой болсон. Үүний үр дүнд улсын хэмжээний тайлан мэдээг системээс харах, олгосон санхүүжилтийг хянах боломжтой болсноор хяналт, хариуцлагын тогтолцоо бүрдсэн. Анхан шатанд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, зохицуулах тогтолцоо нэгж- 760 хамтарсан баг, 6008 гишүүд ажиллаж байгаа бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөлтэй нягт хамтран ажиллаж байна. Хамтарсан баг, нийгмийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж 12 чиглэлийн гарын авлага гаргаж, сургалт өгч, арга зүйгээр хангасан ба хамтарсан багийн нийгмийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчлөх, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.nams.gov.mn -г бий хөгжүүлж, 728 хамтарсан багийн нийгмийн ажилтнуудад Tablet өгсөн.	
5.2. Иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг цахимжуулах	Нийт үйлчилгээний цахимжуулсан хувь	Хөдөлмөр эрхлэлтийн 7 үйлчилгээг e-mongolia цахим системд холбосон.	Төсөв: Улсын төсөв болон бусад эх үүсвэрээр 1,7 тэрбум	Цахим үйлчилгээнд шилжүүлэх боломжтой нийт үйлчилгээний 90-ээс багагүй хувийг цахимжуулсан байна.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Цахим Монгол” зорилтын хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэн бүрт төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлсэн. “Ejob” платформ нь Онлайн портал, мобайл аппликэйшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрдэнэ. Тус платформоос ухаалаг тайлан гарч байхаар хөгжүүлэлтийн ажил хийгдсэн. Үүнд:	30	

						<ul style="list-style-type: none"> - Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/82 тоот тушаалаар баталсан маягтын дагуу хөдөлмөрийн зах зээлийн захиргааны статистикийн сарын тайлан мэдээ, - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тайлан, - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны тайлан мэдээ, - Хөдөлмөрийн хувийн биржийн тайлан мэдээ болон бусад тайлан мэдээ. <p>“Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 2023 онд IT zone ХХК-тай EJob системийн хөгжүүлэлтийг сайжруулах зорилгоор гэрээ байгуулж, гэрээний хугацаа 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дууссан.</p> <p>2024 оны 11 дүгээр сарын байдлаар “Ejob” платформд бүртгэлтэй ажлын байрны тоо–96672, ажил хайгчийн тоо–52760, ажилд зуучлагдсан иргэдийн тоо–26935, мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо-10950 байна.</p> <p>Мэдээллийн сан-1</p>	
5.3.Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах	Нийт үйлчилгээний цахимжуулсан хувь	Нийгмийн даатгалын нийт 34 үйлчилгээнээс 14 нь буюу 42 хувь нь цахимжсан.	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Цахим үйлчилгээнд шилжүүлэх боломжтой нийт үйлчилгээний 90-ээс багагүй хувийг цахимжуулсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас буюу листийг цахимаар олгох шийдвэрийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудын ашигладаг E-Health системд хөгжүүлэлт хийж цахим лист олгох нөхцлийг бүрдүүлсэн. Бүх шатлалын эмнэлэг болон өрх, сумын эмнэлгүүд, хувийн эмнэлгүүдээс нийт 2350 эмнэлэг эмнэлгийн хуудсыг цахимаар олгож байна. Эмнэлгийн	90	

					<p>хуудсыг цахимаар олгох ажлыг зохион байгуулах талаар Эрүүл мэндийн яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/431 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар тогтоох, цахим хяналт, шалгалтыг сайжруулах, сумын төвөөс аймгийн төв рүү тэтгэврийн хувийн хэргийг шилжүүлэхгүй, зөөвөрлөх шаардлагагүй, нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэхээр баруун 8 аймгийн тэтгэврийн хувийн хэргийг 2022 оноос цахимжуулж бүрэн дууссан.</p> <p>2024 оны 12 дугаар сарын байдлаар Дорноговь, Дорнод, Хөвсгөл, Дархан, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах ажлыг эхлүүлж 71 хувьтай байгаа бол, улсын хэмжээнд нийт цахимжуулах 165.2 мянган хувийн хэргээс 81 хувийг цахимжуулаад байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Ай ти зон” компани 2019-2023 онд нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг хөгжүүлэн 2024 оны 01 дүгээр сараас нэвтрүүлж эхэллээ.</p> <p>2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш нийгмийн даатгалын цахим мэдээллийн шинэ системийг нэвтрүүлэх ажил үе шаттайгаар явагдаж, 2024 оны 03 дугаар сарын 15-наас төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал И-Монголиа системтэй холбон ажиллаж байна.</p> <p>E-Mongolia цахим системд нийгмийн даатгалын 17 үйлчилгээг холбосон e-Mongolia цахим системээс 2024 оны байдлаар 15.3 сая удаа нийгмийн даатгалын цахим үйлчилгээг авсан байна.</p> <p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>өдрийн А/101 тушаалаар нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд үндэслэн иргэдэд цахимаар үзүүлэх бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Үндэсний дата төв” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төлөөллийг оролцуулан байгуулсан.</p> <p>Ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сард 3 удаа хуралдаж, цахим хэлбэрээр үзүүлж байгаа нийгмийн даатгалын үйлчилгээний өнөөгийн байдал, тулгарч байгаа болон салбар хоорондын уялдааг хангах асуудлыг хэлэлцэж, хөдөлмөрийн чадвар алдсаны, ердийн болон олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар авах ажлыг туршин хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	
5.4.Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологийн программ хангамжийг хөгжүүлэх	Нэвтрүүлсэн мэдээллийн технологийн систем	НД-ын үйл ажиллагаанд 40 гаруй программ, хангамж ашиглагдаж байна.	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Салбарын уялдааг хангасан мэдээллийн технологийн нэгдсэн систем бий болсон байна.	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Ай ти зон” компани 2019-2023 онд нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг хөгжүүлэн 2024 оны 01 дүгээр сараас нэвтрүүлж эхэллээ. 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш нийгмийн даатгалын цахим мэдээллийн шинэ системийг нэвтрүүлэх ажил үе шаттайгаар явагдаж, 2024 оны 03 дугаар сарын 15-наас төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал И-Монголиа системтэй холбон ажиллаж байна. И-Монголиа цахим системд нийгмийн даатгалын 17 үйлчилгээг холбосон.</p>	100	
5.5.Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах	Нийт үйлчилгээний цахимжуулсан хувь	Нийгмийн халамжийн 26 үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэж байна.	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Цахим үйлчилгээнд шилжүүлэх боломжтой нийт үйлчилгээний 90-ээс багагүй	<p>Нийгмийн халамжийн үйлчилгээг 2020 оноос эхлэн үе шаттайгаар цахимжуулж, 64 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж байна. Цахимжуулалтын хүрээнд бусад төрийн байгууллагын мэдээллийн</p>	90	

					хувийг цахимжуулсан байна.	найдвартай байдал, мэдээлэл солилцоо сайжирч байна. Цахимжуулснаар цаасны хэрэглээ буурч, иргэд хүссэн газраасаа, хүссэн цагтаа хүсэлт гаргах боломжтой болсноос гадна үйлчилгээ авах арилжааны банкаа сонгож дурын дансаа холбож байна. Нийгмийн халамжийн арга хэмжээ нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгоход чухал нөлөөтэй юм.	
	5.6.Салбарын судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, салбарын статистик мэдээллийг ашиглан, шинжлэх ухааны арга зүйгээр тооцож, судлах, түгээх	Шинжлэх ухааны үндэслэлтэй статистик, судалгааны тоо	2020 онд ХНХЯ-ны захиалгаар ХНХСИ болон гадаад, дотоодын судалгаа эрхэлдэг байгууллагууд аар 20 орчим судалгааг хийж гүйцэтгүүлсэн байна.	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Салбарын бодлогын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийгдсэн байна.	Салбарын бодлогын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор ГБХНХЯ-ны захиалгаар Олон улсын байгууллагуудтай хамтран ХНХСҮСИ болон Судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-аар нийт 16 судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Үүнээс бодлогод тусгагдсан томоохон судалгаанаас дурдвал: 1. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал 2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах ойлголт, хандлага, нөхцөл боломж" судалгаа 3. ADB TA 9893-MON Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн халамжийн үр дүнг бэхжүүлэх нь: Монгол Улс дахь туслах технологийн хүртээмж 4. Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт судалгаа 5. Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа 6. Малчдын орлого, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. 7. Нийгмийн халамжийн үйлчилгээ цахимжсантай холбогдуулан Үр ашгийн шинжилгээ. 8. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хэрэгжилтийн судалгаа тус тус хийгдэж, бодлогын	100

						зөвлөмж, дүгнэлт гаргаж, үр дүнг танилцуулсан байна.	
5.7.Их өгөгдлийг бодлого боловсруулахад ашиглах аргамыг тодорхойлох, нэвтрүүлэх	-Их өгөгдөл ашиглаж судалгаа хийсэн тоо -Сервисээр холбогдсон мэдээллийн сангийн тоо	Програм хангамжийг нийт 108 гаруй сервер, 232 гаруй сүлжээний удирдлагын төхөөрөмж ашиглан үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна.	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Их өгөгдлийг бодлого боловсруулахад ашигласан байна.	Арга хэмжээний хүрээнд Орлогыг оруулан тооцох аргачлалыг шинэчлэхдээ төрийн байгууллагуудын мэдээллийн санд тулгуурлан өрхийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх тус мэдээллийн санд үндэслэн зорилтот бүлгийг тодорхойлох, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн. Тус мэдээллийн санд төрийн 5 байгууллагын мэдээллийн санг /УСХ, УБЕГ, НДЕГ, ТЕГ, АТҮТ/ холбож 940 гаруй мянган өрхийн 3,5 сая иргэний мэдээллийг нэгтгэсэн. Тус мэдээллийн санд үндэслэн хийсэн судалгааны үр дүнд УИХ-с баталсан тогтоолын дагуу Монгол улсын нийт хүүхдийн 91%-д хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээг үзүүлсэн. Мөн зорилтот бүлэг тодорхойлох хосолмол аргачлалын хүрээнд 26,954 өрхийн 115,462 гишүүн-иргэний мэдээллийг мөн дээрх байгууллаганд мэдээллийн сан болон өрхөөр зочлох зарчмаар бүрдүүлээд байна. Тус мэдээллийн санд тулгуурлан хүнсний эрхийн бичиг, хууль зүйн туслалцаа үзүүлэх зэрэг үйлчилгээг нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн-гишүүн иргэнд хүргэхээр ажиллаж байна.	70	
5.8.Салбарын мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах	Батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо	Мэдээллийн аюулгүй байдлын түвшин сул байна.	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Мэдээллийн аюулгүй байдлын хууль, журам, стандартад заасан түвшинд хүргэнэ.	Кибер аюулгүй байдлыг хангах журам-ын төслийг боловсруулсан боловч УИХ-с 2022 онд Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбоотой тус хуулийн 7.1-д заасны дагуу “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”-ыг Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталж төрийн байгууллагууд дагаж мөрдөх болсон.	-	
							82.0

-----oOo-----